



Зөвлөмжийн Цуврал

ЗЦ139-16

Нэмэлт, өөрчлөлт 1 (0)

**Аэродром дах шувуу, мал амьтны
аюулаас сэргийлэх менежмент**

2016 оны 2 сарын 05

Ерөнхий зүйл

Иргэний Нисэхийн Удирдах Газрын Зөвлөмжийн Цувралууд нь Удирдлагын зүгээс холбогдох дүрэмд нийцүүлэн мөрдөж ажиллахыг хүлээн зөвшөөрсөн стандарт, практик болон үйл ажиллагааны тухай агуулсан мэдээлэл юм.

АМС нь дан ганц дүрэмд нийцсэн байхад зориулагдаагүй бөгөөд нийцүүлэхтэй холбоотой олон арга замуудыг Удирдлагад гаргаж өгч болох юм. Хэрэгжүүлэх боломжтой шинэ стандарт, практик, эсвэл үйл ажиллагаа олдох үед эдгээр нь холбогдох Зөвлөмжийн цувралд орох болно.

Зөвлөмжийн Цуврал нь дүрмийн шаардлагад нийцүүлэлтийг хялбарчлах Гарын авлагын материалыг (ГМ) мөн агуулдаг.

Зорилго

Энэхүү Зөвлөмжийн Цуврал нь Шувуу ба мал, амьтдын аюулын менежмент, ялангуяа аэродромын шувууны аюулын хяналтыг Иргэний Нисэхийн Дүрэм 139.71- д нийцүүлэхэд туслах материал юм.

Зөвлөмжийн цуврал нь мөн аэродром эзэмшигчид болон орон нутгийн удирдлагуудад зориулсан аэродром орчмын шувуудыг хянахтай холбоотой мэдээллийг агуулсан.

Энэхүү зөвлөмжийн цуврал нь шувууны аюулыг хэрхэн хянах талаар бүх зүйлийг агуулаагүй. Харин аэродром эзэмшигч болон орон нутгийн удирдлагуудад шувууны аюулын менежментийн хөтөлбөрийг батлах, эсвэл сайжруулах, цаашдын ач холбогдлыг дээшлүүлэхэд туслах арга замуудыг эмхэтгэн харуулна.

Холбогдох дүрмүүд

Энэхүү Зөвлөмжийн Цуврал нь Иргэний Нисэхийн Дүрэм 139-д хамааралтай.

Нэмэлт өөрчлөлтийн Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

ИНД-139-ийг монгол болон англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

ЗЦ139-16-г NZ AC139-16-гийн 2011 оны 10 сарын 7-ны өөрчлөлт 0-д үндэслэн боловсруулсан болно.

Агуулга

Оршил	7
Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийн тухай ойлголт.....	8
Үндэслэл	8
Шууд зардал.....	8
Шууд бус зардал	8
Нэмэлт зардал	8
Нэгдмэл ба цогц арга зам	9
Төлөвлөх.....	10
Төсөв.....	10
Ажиллах хүч.....	11
Шувуутай холбоотой зөрчлийн статистик	11
Мэдээлэл цуглуулах.....	11
Мэдээллийг шинжлэх	12
Жишээ:.....	12
Хөтөлбөрийг үнэлэх	13
Мэдээллийг зохицуулах	13
Монгол орны туршлага.....	13
Статистик.....	13
Шувууны зүйл	13
Хүрээлэн буй орчны судалгаа (шувууны аюулын үнэлгээ)	14
Аэродром орчмын газар ашиглалтын үйл ажиллагааны үр дагавар.....	15
Аэродром орчмын газар ашиглалтыг төлөвлөх.....	15
Аюултай газар ашиглалтын туршлага.....	15
Хог булах газар	15
Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж	16
Газар тариалан.....	16
Амралт зугаалгын үйл ажиллагаа	17
Идэвхгүй менежментийн арга барил - амьдрах орчны өөрчлөлт	17
Шувуудад тааламжтай зүйлсийг бууруулах, эсвэл арилгах.....	17
Хүнсний хаягдал.....	18
Ус	18
Орогнох байр.....	19
Үл нэвтрүүлэх арга техник	19
Торлох	19
Утас.....	20
Химийн бүтээгдэхүүн	20
Газрын гадаргууг зохицуулах.....	20
Ургамлын менежмент	20
Өндөр өвсний арга техник	21

Богино өвсний арга техник	21
Урт ба богино өвсний хослосон арга техник.....	21
Мод тарих	22
Идэвхтэй менежментийн арга техник.....	22
Үргээх арга техник.....	22
Дүрс, үзүүлэн маягийн үргээх төхөөрөмж /Visual deterrents/.....	22
Дуу чимээний үргээх хэрэгслүүд	24
Зайлуулах арга техник	24
Хамгаалагдсан зүйлүүд	24
Шилжүүлэх.....	25
Өндөг ба ангаахайг онилох.....	25
Устгал	26
Хамтын ажиллагаа	27
Мэргэжилтний туслалцаа.....	27
Орон нутгийн удирдлагууд.....	27
Байгаль хамгаалах газар	27
Сонирхогч талууд	28
Харилцаа холбоо ба хэвлэл мэдээлэл	28
Бусад мэдээллийн эх үүсвэр	28
Хавсралт - 1	30
Онцгой зүйлүүд - Таних шинж ба хяналтын аргууд	30
Хондон ангир.....	31
Статус ба тохиолдоц:.....	31
Таних шинж - Бие гүйцсэн.....	31
Таних шинж - Залуу шувуу.....	31
Үржил ба үүрлэх орчин	31
Бусад онцлог шинж	31
Зүйлийг хянах аргууд.....	31
Зэрлэг нугас	33
Статус ба тохиолдоц:.....	33
Таних шинж - Бие гүйцсэн.....	33
Таних шинж - Залуу шувуу.....	33
Үржих болон үүрлэх орчин.....	33
Бусад онцлог шинж	34
Зүйлийг хянах аргууд.....	34
Сохор элээ.....	35
Статус ба тохиолдоц:.....	35
Таних шинж - Бие гүйцсэн.....	35
Таних шинж - Залуу шувуу.....	35
Үржлийн хугацаа	35
Бусад онцлог	35

Зүйлийг хянах аргууд	35
Нөмрөг тас	36
Статус ба тохиолдоц:	36
Таних шинж - бие гүйцсэн	36
Таних шинж - залуу шувуу	36
Үржлийн хугацаа	36
Бусад онцлог	36
Зүйлийг хянах аргууд	36
Идлэг шонхор	37
Статус ба тохиолдоц:	37
Таних шинж - бие гүйцсэн	37
Таних шинж - залуу шувуу	37
Үржил ба үүрлэх орчин	37
Бусад онцлог	37
Зүйлийг хянах аргууд	37
Начин шонхор	38
Статус ба тохиолдоц:	38
Таних шинж - бие гүйцсэн	38
Таних шинж - залуу шувуу	38
Үржил ба үүрлэх орчин	38
Бусад онцлог	38
Зүйлийг хянах аргууд	38
Дагуур ятуу	39
Статус ба тохиолдоц:	39
Таних шинж - бие гүйцсэн	39
Таних шинж - залуу шувуу	39
Үржил ба үүрлэх орчин	39
Бусад онцлог	39
Зүйлийг хянах аргууд	39
Өвөгт тогоруу/ өвөгт тогируу	40
Статус ба тохиолдоц:	40
Таних шинж - бие гүйцсэн	40
Таних шинж - залуу шувуу	40
Үржил ба үүрлэх орчин	40
Бусад онцлог	40
Зүйлийг хянах аргууд	41
Хөхвөр тагтаа	41
Статус ба тохиолдоц:	41
Таних шинж - бие гүйцсэн	41
Таних шинж - залуу шувуу	41
Үржил ба үүрлэх орчин	41
Бусад онцлог	41
Зүйлийг хянах аргууд	41

Боршувууны багийн зарим жижиг шувууд (Шоорон эвэртболжмор, Монгол болжмор, Дэрсний жиргэмэл)	42
Статус ба тохиолдоц:.....	42
Таних шинж - бие гүйцсэн.....	42
Үржил ба үүрлэх орчин	42
Бусад онцлог	42
Хар тодол.....	43
Статус ба тохиолдоц:.....	43
Таних шинж - бие гүйцсэн.....	43
Таних шинж - залуу шувуу	43
Үржил ба үүрлэх орчин	43
Бусад онцлог	44
Зүйлийг хянах аргууд.....	44
Алаг шаазгай	44
Статус ба тохиолдоц:.....	44
Таних шинж - бие гүйцсэн.....	44
Таних шинж - залуу шувуу	44
Үржил ба үүрлэх орчин	45
Бусад онцлог	45
Зүйлийг хянах аргууд.....	45
Улаанхушуут жунгаа.....	45
Статус ба тохиолдоц:.....	45
Таних шинж - бие гүйцсэн.....	45
Таних шинж - залуу шувуу	45
Үржил ба үүрлэх орчин	45
Бусад онцлог	46
Зүйлийг хянах аргууд.....	46
Турлиах хэрээ	46
Статус ба тохиолдоц:.....	46
Таних шинж - бие гүйцсэн.....	46
Таних шинж - залуу шувуу	46
Үржил ба үүрлэх орчин	46
Бусад онцлог	46
Зүйлийг хянах аргууд.....	47
Carrion crow.....	47
Статус ба тохиолдоц:.....	47
Таних шинж - бие гүйцсэн.....	47
Таних шинж - залуу шувуу	47
Үржил ба үүрлэх орчин	47
Бусад онцлог	47
Зүйлийг хянах аргууд.....	47

Оршил

Шувуу ба агаарын хөлөг нэг дор зэрэгцэн оршиж, бие биедээ асар их эрсдлийг бий болгодог. Шувууны мөргөлт нь агаарын хөлөгт ноцтой гэмтэл учруулж чадах ба энэ нь бусад аймшигт үр дагавруудыг дагуулдаг.

Иргэний нисэхийн дүрэм 139-өөр гэрчилгээжсэн аэродром эзэмшигч нь шувуутай холбоотой зөрчлийг (мөргөлт, ойр өнгөрөлт) бууруулах “шувуу, мал амьтдын аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөр”-тэй байх ёстой. Уг хөтөлбөрийн гол бүрэлдэхүүн хэсэг блоох шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөр нь аэродром болон түүний орчимд шувууны аюулыг хянахад чиглэнэ.

Хөтөлбөр амжилттай хэрэгжих нь үр ашгийг хамгийн их байлгахад чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг хослуулах (менежментийн идэвхтэй, идэвхгүй аргууд), нэгдмэл цогц аргуудыг ашиглах явдал юм.

Энэхүү Зөвлөмжийн Цуврал аэродром эзэмшигчийн гэрчилгээжсэн, эсхүл гэрчилгээжээгүйгээс үл хамаарч, тэдгээрийн шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрөө тодорхойлох, сайжруулахад нь туслах зорилгоор бичигдсэн бөгөөд шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгасан болно.

Энэ Зөвлөмжийн Цувралын нэгдүгээр хэсэгт тусгагдсан менежментийн арга техникт ерөнхий аргазүйн талаар эмхэтгэж оруулсан ба үүнийг онцгой зүйл шувуудад заавал хэрэглэх шаардлагагүй.

Мөн энэхүү Зөвлөмжийн Цуврал нь аэродром эзэмшигчийн стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг өсгөнө.

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн үр дүнтэй хөтөлбөр нь шувууны мөргөлттэй холбоотой өртөг, эрсдлийг илэрхий бууруулна.

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийн тухай ойлголт

Үндэслэл

Шувууны мөргөлт нь шууд, шууд бус ба нэмэлт зардал гаргадаг.

Шууд зардал

Шувууны мөргөлтийн шууд зардал нь мөргөлтийн үр дүнд агаарын хөлөгт учирсан гэмтлийн шууд өртөгтэй тэнцүү байна.

Агаар сорох талбай ихтэй Жет хөдөлгүүр нь агаар сорох талбай багатай сэнсэт хөдөлгүүрийг бодвол гэмтэлд илүү эмзэг байдаг. Сэнсэт хөдөлгүүрийн хувьд агаар сорох талбай нь сэнсээр халхлагдсан байдаг ба гэмтлийн ихэнхийг сэнс хүлээж авдаг.

Гэвч хөдөлгүүр нь агаарын хөлгийн гэмтэлд өртсөн бусад эд ангитай харьцуулахад цор ганц үнэтэй хэсэг юм. Далавчны хэсэг, гэрэл, явах эд анги, салхины шил, pitot tube зэрэг нь мөн л гэмтэлд өртөмтгий.

Шууд бус зардал

Шувууны мөргөлттэй холбоотой шууд бус зардалд дараах зардлууд багтана. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх болон ослын буултын үед зарцуулсан, асгасан шатахуун
- Солих эд ангийг тээвэрлэх болон засварлах
- Саатсан зорчигч, нисэх багийг байр, нөхөн төлбөр, хоолоор хангах
- Нисэх баг бүхий нэмэгдэл агаарын хөлгийг нислэгт гаргах
- Гэмтсэн агаарын хөлгийг засварлаж дуусах хүртэлх хугацаанд тухайн агаарын хөлгийн төлөвлөгөөт нислэгүүдийг нөхөх
- Гэмтсэн агаарын хөлгийн сул зогсолтын хугацаа
- Агаарын тээвэрлэгчийн төлөвлөгөө маш шахуу, мөн гол зангилаа үйл ажиллагааг хариуцдаг бол тэдгээрээс учрах саатал
- Зорчигчдын итгэл, нэр хүнд алдах

Зорчигчид мөн дараах шууд бус зардлуудыг үүрнэ. Үүнд:

- Холбоо харилцаа алдагдах
- Дамжин суух нислэгээ дахин захиалах
- Саатлаас шалтгаалж бизнесийн боломжуудаа алдах

Нэмэлт зардал

Нэмэгдэл зардал гэдэг нь шувууны мөргөлт гарсантай холбогдуулж аэродром эзэмшигч буюу үйл ажиллагаа эрхлэгч, удирдах байгууллага, бусад аэродром ашиглагчид болон онцгой байдлын албанд учирсан нэмэлт зардлууд юм.

Шувууны мөргөлттэй холбоотой нэмэлт зардалд дараах зардлууд багтана. Үүнд:

- Хөөрч буух зурвас хаагдах
- Нисэх буудлын онцгой байдлын үйл ажиллагаа
- Түргэн тусламж, гал, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ба эмнэлгийн үйлчилгээ гэх мэт нисэх буудлын гаднах үйлчилгээ
- Хөөрч буух зурвасны цэвэрлэгээ ба засвар
- Ирэх ба явах нислэгүүдийн саатал
- Агаарын хөлгүүдийн сааталтай холбоотой нэмэлт шатахуун
- Аэродромын шувуу, мал амьтны менежментийн хөтөлбөрийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх
- Байцаах, аюулгүй ажиллагааг шинжлэн шалгах
- Шувууны аюулаас сэргийлэх менежменттэй холбоотой удирдлагын зардал

Нэгдмэл ба цогц арга зам

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд төрөл бүрийн нөөц, агаарын тээврийн сонирхогч талууд (аэродром эзэмшигч, нислэгийн хөдөлгөөний удирдлага ба агаарын хөлгийн ашиглагчид, газар ашиглалтад нөлөөлөх байгууллага буюу орон нутгийн удирдлага, төрийн байгууллагууд г.м), түүнчлэн Байгаль хамгааллын хэлтэс, биологич, шувуу судлаачдыг оролцуулах хэрэгтэй.

Үр ашигтай хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нэгдмэл аргыг хэрэглэхдээ аливаа нэг зүйл шувууг бууруулах эсвэл нэг зүйл шувууг бууруулах зорилгоор үүсгэсэн орчин нь бусад шувуудын хувьд ч таагүй байх нөхцлийг хангах үүднээс тухайн газар нутаг дахь шувуудын бүх зүйлд үнэлгээ хийнэ.

Аэродром бүр экологийн тогтоц, хүрээлэн буй орчны нөхцлөөрөө ялгаатай тул хэдий ашиглаж буй хяналтын тоног төхөөрөмжүүд нь хоорондоо адил байлаа ч нэг зүйлийн шувуудад нөлөөлөх үр дүн нь өөр өөр байх боломжтой.

Тиймээс хөтөлбөр нь аэродром бүрийн онцлогт тохирсон, үр дүнг нь нарийвчлан хянаж болдог байх хэрэгтэй.

Менежментийн идэвхтэй ба идэвхгүй арга барилуудын аль аль нь шувууны менежментийн үр ашигтай байдлыг хангах ёстой.

Менежментийн идэвхтэй арга барилууд нь идэвхгүй арга хэмжээний **эсрэг нөлөөтэй** бөгөөд идэш тэжээлийн боломж, ус, аэродромын ургамлыг бууруулдаггүй. Урт хугацааны менежментийн идэвхгүй арга барилууд (усан санг байхгүй болгох, газрын гадаргад өөр ургамал тарих зэргээр шувуудын амьдрах орчныг бууруулах г.м) нь менежментийн идэвхтэй арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг бууруулдаг.

Шувууд амьдрах орчноо маш хурдан буй болгодог, тиймээс хяналтын арга техникээр хэт үйлчлэх эсвэл хэт олон давтах, эсвэл дүрсээр айлгах хэрэгслүүд нь удаан хугацааны турш хөдөлгөөнгүй байх үед дасан зохицдог. Тиймээс хөтөлбөрийг үр

ашигтай байлгахын тулд үйл ажиллагааны цар хүрээг удирдан зохион байгуулах нь чухал.

Төлөвлөх

Менежментийн идэвхтэй арга техник нь шувууны аюулыг шуурхай бууруулдаг байх хэрэгтэй. Гэхдээ энэ арга нь байнгын үр ашигтай, шуурхай байдлыг хангаж хийгдэх нь чухал.

Стратегийн урт хугацааны арга зөвшөөрөгдсөн байх хэрэгтэй. Менежментийн идэвхгүй арга техникүүд нь хэрэгжихдээ удаан бөгөөд богино хугацаанд илүү их зардал гаргадаг боловч үр дүн нь идэвхтэй арга техникээс илүү тогтвортой байдаг.

Идэвхгүй арга техник нь шувуудын амьдрах орчныг өөрчлөх, аэродром орчимд шувууд цуглах шалтгаан болж буй зүйлсийг бууруулах зорилготой. Зарим менежментийн идэвхтэй арга техникүүдийг удаан хугацаагаар үр дүнтэй ашиглаж болдог. Жишээлбэл, төвөг учруулж буй зүйл шувуудын дэгдээхэйлэх өндгийг **manipulating** хийснээр ангаахай буюу дэгдээхэйн тоог бууруулах. Ингэснээр хэдэн жилийн дараагаар бие гүйцсэн шувуудын тоо ба үржлийн амжилт нь буурахад хүрнэ.

Төсөв

Шувууны аюулын менежментийн хөтөлбөр хүчин төгөлдөр байхын бас нэг чухал хэсэг нь төсөв төлөвлөх явдал юм. Аэродром эзэмшигчид (Aerodrome operator) нь жилийн төсвөө бэлтгэхдээ менежментийн идэвхтэй ба идэвхгүй аргыг анхаарах хэрэгтэй.

Үүнийг дагаж мөрдөх өртөг (шувууны мөргөлтийн үр дүнд үүссэн хариуцлагын эсрэг хамгаалалт) эсвэл маш энгийн, агаарын навигацийн орлогын хамгаалалт

These can be viewed as compliance costs (шувууны мөргөлтийн үр дүнд үүссэн хариуцлагын эсрэг хамгаалалт) or, quite simply, as protection of aeronautical revenues.

Зардал нь шувууны аюулын менежментийн хөтөлбөрөөс хамаарч улирлын, эсвэл нэг жилийн хугацаанд тогтмол байж болно.

Ажилчин, менежментийн идэвхтэй арга техникийг хэрэгжүүлэхэд ашигласан материал ба амьдрах орчныг өөрчлөх гэрээт байгууллага, эсвэл дэмжлэг үзүүлэгчдийг тооцоонд оруулах хэрэгтэй.

Аэродром эзэмшигчид нь дэд бүтэцдээ байнгын зүйл суурилуулахдаа, эсвэл шувууны аюулын менежментийн хөтөлбөрийн үр дүнгээр тоног төхөөрөмж худалдан авахдаа хөрөнгийн зардлын төсвөө тооцоолох хэрэгтэй.

Ажиллах хүч

Цөөхөн аэродром эзэмшигчид шувуу хянах ажилтан ажиллуулахыг зөвтгөдөг, тиймээс бусад онцгой үүрэгтэй ажилчдыг ашигладаг.

Ажилтан нь шувуудын зүйлийг тодорхойлох, хянах, хүрээлэн буй орчны менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар сургагдсан байх ёстой. Ажилтанд зориулсан шувууны аюулыг бууруулах менежментийн шалгах хуудас нь дэд бүтцийн загвар, барилга байгууламж болон засвар арчлалтын ажиллагаанд хэрэглэхэд тохиромжтой байх хэрэгтэй.

Аэродромд ажиллаж буй ажилтан, түрээслэгч, концессионер, гэрээ байгуулагчид нь шувуугаар үүсгэгдэх аюул, эсвэл ажлынхаа орчинд шувуудын анхаарал татах зүйлсийг хэрхэн бууруулах, арилгах талаар ойлголттой байх.

Шувуутай холбоотой зөрчлийн статистик

Мэдээлэл цуглуулах

ИНД-12 Осол, зөрчил, статистикт агаарын хөлгийн нисгэгч шувуутай холбоотой зөрчлийг Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээлэхийг шаарддаг. Шувуутай холбоотой зөрчлийн талаарх нарийвчилсан мэдээллийг нисгэгчид Иргэний нисэхийн ерөнхий газарт дамжуулах зорилгоор ихэнх тохиолдолд хамгийн ойрын Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгжид өгдөг.

Иргэний нисэхийн ерөнхий газар шувуутай холбоотой зөрчил нисэх буудалд, эсвэл нисэх буудлын гадна тохиолдсон эсэхийг ангилах дараах системийг хүлээн зөвшөөрсөн.

Агаарын хөлөг газардах эсвэл ойртолт үйлдэх явцдаа газрын гадаргаас дээш 200 фүүт буюу түүнээс доош өндөрт, эсвэл хөөрөлт үйлдэх, өндөр авах үедээ 500 фүүт буюу түүнээс доош өндөрт шувуутай мөргөлдсөн бол түүнийг “Нисэх буудалд” тохиолдсон шувууны мөргөлт гэнэ. Агаарын хөлөг ойртолт үйлдэх явцдаа газрын гадаргаас дээш 200 фүүтээс өндөрт, өндөр авах үедээ 500 фүүтээс өндөрт тохиолдсон шувууны мөргөлтийг “нисэх буудлын гадна” болсон тохиолдол гэнэ.

Энэ системийг ашиглаж шувуутай холбоотой зөрчил нисэх буудалд, эсвэл нисэх буудлын гадна тохиолдсон эсэхийг ангилах шийдвэрлэх мэдээлэл нь агаарын хөлгийн нислэгийн үе шат, нислэгийн өндөр юм.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь аэродром эзэмшигчдийг статистикийн тайлан мэдээ ба зөрчил, хандлагатай холбоотой тайлбараар хангадаг. Зарим аэродром эзэмшигчид Монгол улсын агаарын тээврийн компаниудыг шувуутай холбоотой зөрчлийн мэдээгээр хангадаг. Энэ нь аэродром эзэмшигчдийг сүүлийн үеийн шинэлэг мэдээ болон зөрчил учирсан агаарын хөлгийн маяг, цаг хугацаа, өндөр ба хурд,

агаарын хөлгийн нислэгийн үе шат, боломжтой бол шувууны зүйл, мөргөлдсөн шувуудын тоо гэх мэт ашиглах боломжтой илүү өргөн хүрээний мэдээллээр хангадаг. Энэ мэдээлэл нь зөрчлийн **in-house analysis** хийхэд зориулагдсан.

Мэдээллийг шинжлэх

Дата анализ нь шувууны аюулыг бууруулах менежментийн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, аливаа бэрхшээлтэй асуудлыг бууруулахад шаардлагатай үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад тус болдог.

Цаасанд суурилсан мэдээллийн систем нь боловсруулахад төвөгтэй, дутагдал ихтэй тул мэдээллийн сангийн программ хангамж ашиглах нь илүү үр ашигтай, хялбар байдаг.

Агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд In-house analysis хийхэд хялбар байдаг. Мэдээллийн үзүүлэлтийн тоймийг Иргэний нисэхийн ерөнхий газраас авна.

Шувуутэй холбоотой зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ дараа зүйлсийг анхаарна. Жишээ нь:

- Аэродром дээр, эсвэл гадна тохиолдсон эсэх
- Мөргөлдсөн шувууны зонхилох зүйл
- Мөргөлдсөн агаарын хөлгийн зонхилох маяг
- Мөргөлт болсон өдрийн зонхилох цаг (шувуудаас илүүтэйгээр агаарын хөлгийн нислэгийн оргил ачааллын үе байсан байж болзошгүй)
- Мөргөлт болсон улирал (идэш тэжээлийн олоц, эсвэл нүүдлийн хэв маягаас хамаарсан байж болзошгүй)
- Мөргөлт болсон аэродромын зонхилох талбай (шувуудын амьдрах орчны онцгой нөхцөл, нүүдлийн шувуудад тааламжтай орчин бүрдүүлсэн хөөрч буух зурвасны аль нэг төгсгөл байж болзошгүй)
- Мөргөлт тохиолдсон зонхилох өндөр (нүүдлийн хэв маягийг тодорхойлж болно)
- Хэрэв мөргөлт нисэх буудлын гадна тохиолдсон бол ямар тохируулга хийх

Мөн энэхүү анализ нь авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хэрэгжилтийн байдлыг үнэлэх ач холбогдолтой.

Жишээ:

Шувуутай холбоотой зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийж, тохирох залруулгыг хийснээр шувуутай холбоотой зөрчлийг бууруулж болно.

Жишээ нь, аэродром эзэмшигч ба агаарын тээвэрлэгч байгууллагад ийм тохиодол гарчээ. В737 маягийн агаарын хөлөг том оврын бусад агаарын хөлөгтэй харьцуулахад нүүдлийн шувуудтай илүү олон удаа мөргөлджээ. Шалгалтаар В737 агаарын хөлгийн хөөрөлтийн цэг бусад тийрэлтэт агаарын хөлгийнхөөс ойр байсныг илрүүлжээ. Тиймээс В737 шувуудын дундуур нисч, харин бусад том оврын агаарын хөлгүүд түүний доогуур өнгөрдөг байжээ. Тиймээс В737-ийн хөөрөлтийн цэгийг өөрчлөхөөр шийдсэн

тул тэд шувуудын нисэх хэсгийн доогуур өнгөрч, үр дүнд нь мөргөлтийн тоо цөөрсөн.

Хөтөлбөрийг үнэлэх

Шувуутай холбоотой зөрчлийн мэдээнд дүн шинжилгээ хийх нь шувууны аюулыг бууруулах менежментийн хөтөлбөрийн үр дүнг үнэлэх үнэлгээний нэг хэсэг юм. Гэхдээ үр дүн нь зөв хандлагатай байна уу, эсвэл гажиж байна уу гэдгийг илрүүлэхдээ олон жилийн тогтмол мониторинг ба дүн шинжилгээ хийж байх хэрэгтэй.

Мэдээллийг зохицуулах

Шувуутай холбоотой зөрчил мэдээлэгдсэн байх нь маш чухал бөгөөд энэхүү мэдээлэл нь шувууны аюулын шалтгааныг тогтоох, оролцогч талууд (аэродром эзэмшигч, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн ерөнхий газар) эрсдлийг зохицуулах талаар шийдвэр гаргахад тус болдог. Шувуутай холбоотой зөрчлийн мэдээ нь тухай орон нутаг, улс болон дэлхийн түвшинд чухал ач холбогдолтой.

Монгол орны хувьд “шувуутай холбоотой зөрчил” гэдэгт дараах тохиолдлыг ойлгоно:

- Агаарын хөлөг нэг, эсвэл олон шувуутай мөргөлдсөн (шувууны мөргөлт).
- Агаарын хөлгийн нислэгийн явцад нэг, эсвэл олон шувуу маш ойрхон өнгөрч нисгэгчийг түгшүүр зарлахад хүргэсэн (ойр өнгөрөлт).

Монгол улсын аэродром эзэмшигчид шувууны үлдэгдэл аэродром дээрээс олдсон тохиолдолд Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээллэж (ИНД-12 дагуу) энэ талаарх болсон явдал тодорхой болох, эсвэл шувуутай холбоотой зөрчлийн баримтаар нотлогдоогүй буюу сэжигтэй тохиолдлын бүртгэлд ордог.

Монгол орны туршлага

Статистик

2007-2015 онд Монгол улсад шувуутай холбоотой 50 гаруй зөрчил бүртгэгдсэн:

Шувууны зүйл

Шувуутай холбоотой мэдээлэгдсэн зөрчлийн бүртгэлээс харахад цөөн зүйл шувууд давамгайлсан байдаг:

Ялангуяа “жижиг шувуу”, “элээ”, “хэрээ” болон “тогоруу” зэрэг шувуутай тохиолдсон зөрчил олон байна.

Энэхүү баримт бичгийн сүүлийн хэсэгт эдгээр шувууд болон учруулах аюулыг хянах үр дүнтэй аргын талаар тусгасан.

Жижиг шувуудыг хянах арга нь ямар зүйлийн шувуу гэдгээс үл хамааран ерөнхийдөө ижил байдаг. Хэрвээ асуудал үүсгэж буй зүйл шувуу энд тусгагдаагүй бол тусгайлсан хөтөлбөр боловсруулахад тань туслах шувуу судлаачийн зөвлөгөөг авах хэрэгтэй.

Хүрээлэн буй орчны судалгаа (шувууны аюулын үнэлгээ)

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөр боловсруулах хамгийн эхний алхам нь хүрээлэн буй орчны судалгаа буюу шувууны аюулын үнэлгээ юм. Энэ судалгаа нь шувуудын анхаарлыг аэродром руу татаж буй хүчин зүйлд чиглэх бөгөөд ямар нэг томоохон амьдрах орчныг өөрчлөхөөс өмнө бүрэн хийж дуусгасан байх хэрэгтэй.

Судалгаагаар дараах зүйлсийг тодорхойлсон байх хэрэгтэй:

- Тухайн газар дах аюултай шувуудын тоо
- Тухайн газар дах шувуудын зүйл
- Шувууд орон зай болон цаг хугацааны хувьд хэрхэн тархсан байдал
- Шувууд яагаад тухайн газарт байгаа шалтгаан
- Аэродром болон агаарын хөлгийн нислэгийн замтай хамааралтай шувууд хаагуур, яаж шилжиж нисдэг

Мөн тухайн газрын географи, гидрологи, хөрс, уур амьсгал болон ургамалжилт, барилга байгууламжийн хийц загвар, газар тариалан, хог хаягдалын зохицуулалт зэрэг хүний үйл ажиллагаанд үнэлгээ хэрэгтэй.

Энэ судалгаа нь аюултай зүйл шувууд яагаад тухайн аэродромд тохиолдож байгааг ойлгоход шаардлагатай бодит мэдээллээр хангах бөгөөд үүний үр дүнд таны онцлон анхаарч үзэх шаардлагатай орчны өөрчлөлтийн талаар зөвлөдөг. Зарим тохиолдолд шувууны зүйлийн судалгааг илүү дэлгэрэнгүй байдлаар хийхэд мэргэжлийн хүн шаардлагатай болдог. Бусад тохиолдолд ерөнхий судалгаа нь шувууны аюулын голлох байршлыг тогтооход тус болно.

Шувууны аюулын менежментийн хөтөлбөр нь аэродромоос бүх шувуудыг зайлуулах биш, эрсдлийг удирдан зохицуулах тухай гэдгийг ойлго (зарим аэродром эзэмшигчид үүнийг үл биелэгдэх нөхцөл гэж үздэг).

Тохиолдлын зарим хослол нь эрсдэл учруулдаг байж болох тул шувуудын зуршил болсон зан төрх ба агаарын хөлгийн нислэгийн замын харилцан хамаарлыг тогтоох нь чухал юм.

Шувуудын бүртгэлийг тогтмол хийж (жил бүр), тоо толгойн хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг тооцож үзэх нь эцсийн дүнд шувууны аюулын менежментийн хөтөлбөрийн үр ашгийг үнэлэхэд тус болдог. Энэхүү судалгаандаа өөрийнхөө өмнөөс Шувуу судлалын нийгэмлэгийн орон нутгийн гишүүд, эсвэл судлаач оюунуудыг ашиглаж болно.

Аэродром орчмын газар ашиглалтын үйл ажиллагааны үр дагавар

Аэродром орчмын газар ашиглалтыг төлөвлөх

Хэдийгээр та шувуудын анхаарлыг татдаг аэродромын хүчин зүйлсийг бууруулахтай холбоотой ашиглалтын үйл ажиллагаанд өөрийн газар дээрээ хяналт тавьж чадах хэдий ч аэродромын хил болон таны нөлөөллийн хүрээнээс гадна буй газар ашиглалтын үйл ажиллагаа нь таны үйл ажиллагаатай зөрчилдөж болзошгүй.

Тухайлбал, шувууд аэродром дээгүүр байнга хөндлөн нисэх үед (хоноглох болон хооллох гаруудын хооронд нисэхдээ) хүндрэлтэй асуудлууд үүсдэг.

Олонх аэродромд байдаг хамгийн том асуудал нь аэродромын орчмын нэг юмуу хэд хэдэн хог хаях төвлөрсөн цэгүүд юм. Эдгээр нь шувуудыг ялангуяа, олонх цахлай, элээг хоолоор хангадаг тул тэд аэродром орчмын газрыг хэсүүчлэх болон амарч суух газраа болгон ашигладаг.

Тиймээс аэродром эзэмшигчид хот төлөвлөх үед танилцуулга хийх, эсвэл дүүргийн төлөвлөлтийг эргэн харах ба батлагдсан хуулийг сахих чиглэлээр орон нутгийн удирдлагатай хамтран ажиллах нь хамгийн чухал. Ингэснээр хотын захиргаа шувуудын популяцид нөлөөлөх энэхүү үйл ажиллагаа аэродромын орчимд болон агаарын хөлгийн ойртолт, хөөрөлтийн бүсэд байвал агаарын тээвэрт аюул учруулж болзошгүйг мэднэ.

Аюултай газар ашиглалт батлагдчихсан бөгөөд хориглолт, хязгаарлал хийх боломжгүй болсон үед залруулах арга хэмээг авч болох юм. Жишээ нь:

- Эзэд болон менежерүүдэд үйл ажиллагааных нь улмаас аюул үүсгэгдээд байгаа талаар мэдэгдэх
- Шувуудын анхаарлыг татах үйл ажиллагааг бууруулах хөтөлбөр бий болгоход туслах

Аюултай газар ашиглалтын туршлага

Хог булах газар

Хог булах газруудыг аэродромд ойр байрлуулж болохгүй, учир нь тэд хүнсний нөөцөөр элбэг учир хог түүгч шувуудын анхаарлыг маш ихээр татдаг.

Гэхдээ хог булах газрууд шувуудын анхаарлыг бууруулах зүйл хийх боломжтой:

- шувуудыг нисэх үед саад болох зорилгоор дээгүүр нь утас татах
- хог асгах ажлын талбайг аль болох бага байлгах ба цооногт агуулагдсан байвал шувууд нэвтрэх боломжийг хязгаарладаг давуу талтай.
- хог булах газар ажиллахгүй үед хаягдлыг өдөр бүр хөрсөөр дарж булснаар хүнсний эх үүсвэрийг бууруулах боломжтой.

Асгасан хүнсний хаягдал тэр даруйдаа хучигдсан эсэхэд сайтар хяналттай байх хэрэгтэй.

Аэродромд ашиглагддаг ихэнх идэвхтэй менежментийн арга техник нь хог булах газруудад мөн үр дүнтэй ашиглагддаг. Хүнсний үлдэгдлийг бууруулах нь шувууны популяцийг бууруулна.

Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж

Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг мөн аэродромд ойр байршуулахгүй байх хэрэгтэй. Эдгээр газрууд нь тунадасжуулах эсвэл агааржуулах усан сангууд эсвэл усны болон далайн шувуудын анхаарлыг татахуйц өргөн уудам устай байдаг.

Усан сангуудад болон түүний орчин шувуудын анхаарлыг татах боломжийг хамгийн бага болгох зорилгоор хяналтын аргуудыг ашигладаг. Үүнд:

- Усан сан дээгүүр утас татах
- Шувуудын амрах, усан сангийн эрэг орчимд суух, нисэхэд саад учруулах болон тэднийг усанд байх үед махчин амьтдын үзэгдэх боломжийг хаахын тулд усан сангийн хажуу гадаргуугийн налууг ихэсгэх
- Шувуудын амрах боломжтой талбайг бууруулах, тэдний ойр орчмоо ажиглах болон нисэх үед саад хийхийн тулд усан санг тойруулан ургамлжуулах
- Усан сан ашиглаж байгаа тохиолдолд дээд гадаргууг утсаар хэрэх, эсвэл торлох хэрэгтэй.

Газар тариалан

Үр тариа

Орон нутгийн аэродромууд ихэвчлэн газар тариалангаар хүрээлэгдсэн байдаг. Тэр ч байтугай аэродром эзэмшигчид үр тарианы ашигтай газрын тодорхой хэсгийг ашигладаг (хүнсний ногоо, улаанбуудай, жимс, эсвэл тэжээлийн өвс ургамал).

Хэрэв тариалалт аэродром орчимд хийгдэхээр бол тухайн газар дахь шувуудын нөлөөллийг тооцоолох ургамал судлаач, эсвэл шувуу судлаачдын зөвлөгөөг авах хэрэгтэй. Ургамлын үр, тариа нь шувуудын анхаарлыг татах чухал хүчин зүйл болох тул аль болох түүнээс зайлсхийх хэрэгтэй.

Шувуудын анхаарлыг татах газар тариалангийн холбогдолтой асуудлаар ойр орчмын тариаланчидтай хэлэлцэх. Тариалангчидтай хамтын ажиллагаагаа хөгжүүлснээр төлөвлөсөн үр тарианы сонголтод нөлөөлөх боломжтой болох, эсвэл тариалалтыг өөрчлөх талаар наад захын мэдээлэл олгосон байх болно. .

Газар хагалах, боловсруулах нь **үр, шавьж идэшт болон махчин шувуудын** анхаарлыг татдаг.

Шувуудын аюулыг бууруулахын тулд аэродромын ойролцоо байгаа газар тариалангийн ажлын цаг хугацаанд нөлөө үзүүлэхийг хичээх хэрэгтэй (агаарын хөлгийн нислэг хөдөлгөөн хамгийн бага байх үед буюу шөнийн цагаар үйл ажиллагаа эрхлүүлэх гэх мэт).

Амьтад

Мал аж ахуй мөн л шувуудыг татдаг, ялангуяа мал төллөх улиралд шувуудын идэш тэжээлийн нөөц элбэг болдог.

Та эдгээр тохиолдолд шувуудыг бууруулах талаар бага зүйл хийж чадах боловч энэ үед малаа аэродром орчмын бэлчээрээс холдуулах талаар малчдаас хүсэх хэрэгтэй.

Мал худалдаалдаг газар нь шувуудын идэш тэжээлээр элбэг байх тул мөн л шувуудыг татдаг (тухайлбал, ялаа болон амьтанд татагддаг бусад шавьжууд). Энэ мэт үйл ажиллагааг аэродромд ойр байлгахгүйн тулд орон нутгийн удирдлагуудтай хамтран ажилла.

Амралт зугаалгын үйл ажиллагаа

Газар

Монголчууд задгай газар салхинд гарах дуртай (спортын талбай, цэцэрлэгт хүрээлэн, хээр хөдөө гэх мэт). Эдгээр газартаа хоол хүнсний хог хаягдал үлдээж явдаг учир шувууны аюул тохиолдох өндөр эрсдэлтэй байдаг. Бусдыг үдэн гаргадаг газар, эсвэл аэродромын үйл ажиллагааг харж сонирхдог газрууд нь мөн ижил шалтгаанаар аюул үүсгэдэг. Эдгээр хооллох боломжтой газарт тохиолдож буй шувууд нь хоноглох газраасаа аэродром, эсвэл нислэгийн бүсээр дайран нисч өнгөрч буй шувууд бөгөөд аэродромыг түр амрах газраа болгодог.

Эдгээр газар дахь шувуудын идэш тэжээлийг бууруулах, хүнсний хагдал ба газрын менежментийг сайжруулахын тулд орон нутгийн удирдлагууд болон спорт клубуудтай хамтран ажилла.

Ус

Зарим аэродромууд голын эрэгт байрладаг. Загасчлал нь монголчуудын хувьд түгээмэл хобби юм. Хэрэв ус усны шувуудыг татаж байвал бол усыг үнэлж, хянах шаардлагатай.

Загас цэвэрлэсэн, эсвэл хог хаясан газарт шувуу цуглаж агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй учир орон нутгийн загасчдыг болиулах хэрэгтэй.

Аюул учруулж болох энэ төрлийн хүнсний хаягдлыг бууруулах тал дээр орон нутгийн усан зогсоолын эзэн болон загасчлалын клубуудээс туслалцаа авах холбоо харилцаа тогтоо.

Энэ төрлийн үйл ажиллагааг зогсоох үүднээс тухайн газруудад үзүүлэн тэмдэг байрлуул.

Идэвхгүй менежментийн арга барил - амьдрах орчны өөрчлөлт

Идэвхгүй менежментийн арга барил гэдэг нь шувуудын амьдрах орчны тааламжтай байдлыг бууруулах, эсвэл тааламжгүй болгон өөрчлөх явдал юм.

Аэродром болон түүний орчимд нүүдлийн, эсвэл суурин шувуудын анхаарлыг татах үндсэн зүйл нь идэш тэжээл, ус ба хооллож, амрах нуувч, үүрний аюулгүй байдал юм.

Шувуудад тааламжтай зүйлсийг бууруулах, эсвэл арилгах

Аэродром дахь шувуудын идэш тэжээлд хүнсний хог хаягдал, үрт болон усны

ургамал, сээрнуруугүйтэн, чийгийн улаан хорхой зэрэг орно. Ямар ч тохиолдолд хоол хүнсийг анхааралтай, тогтмол хянаж бай.

Хүнсний хаягдал

Идэж болдог хаягдлыг зохицуулах нь чухал.

Аэродром орчимд буй ресторан болон хоол хийдэг бусад газруудаас хүнсний хаягдлаа зохистой саванд агуулж байхыг шаардаж бататга.

Машин зогсоол, үдэлтийн газар болон хүмүүс цугладаг бусад задгай газруудад хүнсний хаягдал орхиж шувуудын анхаарлыг татахгүй байхтай холбоотой арга хэмжээ авах. Эдгээр газруудад шувуу хооллохыг хориглосон тэмдэг байрлуулах.

Ургамал

Энэ баримт бичгийн “газрын гадаргыг зохион байгуулах” хэсгийн төгсгөлд ургамал хянах арга хэмжээний талаар хэлэлцсэн.

Чийгийн улаан хорхой

Чийгийн улаан нь бүх төрлийн шувуудын анхаарлыг хүчтэй татдаг. Бороотой үед Чийгийн улаанууд хучилттай талбайн гадаргууд гарч ирдэг. Урт хугацааны шийдэл нь Чийгийн улааныг устгах бодис цацах хөтөлбөр юм. Ургамалжсан талбай, эсвэл аэродромын хөдөлгөөнт бүсийн захаар цацна.

Шавьж

Бүгэг эрвээхэй, тэмээлзгэнэ, цох зэрэг шавьжийн авгалдай, бие гүйцсэн хэлбэр нь олон тооны шувуудыг татдаг. Шувуунд идэгдэж буй шавьжийн зүйлийг тодорхойлоход мэргэжилтний туслалцаа хэрэг болох байх. Ихэнх шавьжууд улирлын, ялангуяа хавар, зуны улиралд асуудал үүсгэдэг.

Ургамалжсан талбайг хороор шүршихийг жил бүр, зорилтот зүйл шавьжууд гарч ирсэн үед хэрэгжүүлнэ.

Ус

Нугас, цахлай ба эргийн шувууд усанд хөвөх болон зогсохоор тэмүүлдэг.

Усанд зогсох боломж олгож буй бүх төрлийн бодит биетүүдийг өөрчил, эсвэл бууруул. Жишээ нь:

- Бороо орсны дараа нүх, эсвэл хонхорт тогтсон усыг сувгаар урсгах болон булах
- Усны бохирдсон сувгийг цэвэрлэх, ялангуяа үерийн усны шуудуу, учир нь тэнд шувууд зөвхөн уух болон сэлэхийн тулд татагддаггүй, шавьж, усны амьдралаар тэтгэгддэг.
- Шувууд суухаас сэргийлж усан сангийн усыг хучиж далдлах
- Эргээс дээш буй махчин амьтдыг харж чадахгүй үед шувуудын усанд амарч суух

байх давтамж буурдаг тул усан сангийн эрэг орчмын газрыг өндөрлөж саад хийх.

- Шуудууг өндөрлөж налуулснаар ус түргэн урсаж гарах боломжтой болно.
- Усан сангийн налуу эрэг дагуу ургасан зүлэг болон бусад ургамлыг тайрах
- Шуудуунуудыг газар доорх ус зайлуулах суваг, эсвэл хоолойгоор солих

Аэродром дотор ус намгархаг газар байгаа бол Хамгааллын Хэлтсийн мэргэжилтнээс тусламж зөвлөгөө авах.

Орогнох байр

Аэродромууд шувуудад хэсүүчлэх, суух, хоноглох, үүрлэхэд тааламжтай орчин бүрдүүлдэг. Шувууд гол төлөв дээврийн ирмэг, цамхаг болон дүүжин шат зэрэг байгууламжуудад хорогдох байраа хайдаг. Тэд дээвэр, булан тохой, зай завсар, нүх, ховил болон аль болох өндөр өвс, бут, модонд үүрлэдэг. Гэхдээ нэгэнт тодорхой болсон эдгээр газруудыг шувуу орогнохоос сэргийлж өөрчлөх боломжтой.

Хучилттай талбай болон богино өвстэй задгай талбай нь ойр орчмын үзэдэх байдлыг сайжруулдаг учир шувууд ойртон ирж буй махчин амьтдыг харж, аюулгүй байдлаа хангадаг.

Хучилттай талбай нь дулаан хуримтлуулдаг учир жилийн зарим үед оройн цагаар дулаан байдаг.

Хучилттай талбай нь шувуудын хувьд яс унагах хатуу гадаргуу болдог бөгөөд тэд яс хагалан, дотроос нь идэх юм авах дуртай байдаг.

Үл нэвтрүүлэх арга техник

Торлох

Торлох арга нь шувууд хооллох, хоноглох, эсвэл үүрлэх талбайд нэвтрэхийг зогсоох зорилгоор дотор болон гадна төрөл бүрийн орчинд хэрэглэгддэг.

Торлох аргыг ихэвчлэн дараах тохиолдолд хэрэглэдэг:

- Барилгын онгорхой тааз, эсвэл нэвт гарсан хоолойд
- Жижиг цөөрөм, ус зайлуулах сувгийн дээгүүр
- Газар шорооны ажлын үеэр шувууд чийгийн улаан хорхой, шавьж, шинэ үр идэхийг бууруулах зорилгоор бага хэмжээний газрын дээгүүр
- Шувууд хоноглохоос сэргийлж жижгээс дунд зэрэг хэмжээтэй модон дээгүүр (гэвч шувуу саатуулах бусад төрлийн харагдах хэрэгслүүд нь гоо зүйн хувьд илүү тохиромжтой байдаг)
- Гэхдээ хэрвээ тор сулраад ба агаарын хөлгийн хөдөлгүүрт орвол аюул учруулах боломжтой. Тиймээс үүнийг агаарын хөлгийн хөдөлгөөнт бүсэд ашиглахыг сайшаадаггүй.

Утас

Утас нь шувуудыг тодорхой газраас зайлуулахад олон янзаар ашиглагддаг.

Утсыг гадаргуугаас ойролцоогоор 0,75-1 метрт байрлуулах нь буухаар ойртож буй шувуудад саад учруулдаг.

Утсыг ойролцоогоор 1 метр квадрат хэмжээгээр, эсвэл зорилтот зүйлээс хамааруулан илүү том хэмжээгээр торлон байрлуулдаг. Энэ нь дундаас том биетэй шувуудад зориулж хавтгай дээвэр дээр болон агааржуулах цөөрмийн дээгүүр татахад үр дүнтэй. Гэхдээ үүнийг жижиг шувуудын зүйлийн эсрэг ашиглахад үр ашиггүй.

Утсыг хогийн цэг зэрэг зарим газруудад гадаргуугаас нилээд өндөрт байрлуулан ашигладаг. Энэ нь шувуудын нислэгт саад учруулдаг бөгөөд тухай газраас залхдаг.

Шувуудад, ялангуяа жижиг шувууд барилгын тавцан, эсвэл цамхаг, цахилгааны шон дээр суухад саад болох зорилгоор утас, эсвэл метал зүүнүүдийг хэсэгчилсэн ба үргэлжилсэн хэлбэрээр ашигладаг. Эдгээр зүүнүүд нь шувуу суух боломжгүй болгодог.

Химийн бүтээгдэхүүн

Барилгын тавцан ба бусад хавтгай гадаргууд шувуу хоноглохыг болиулах зорилгоор гол төлөв наалдамхай чанарын химийн бүтээгдэхүүнийг ашигладаг. Гэхдээ энэ нь богино хугацаанд үр ашигтай байдаг учир үр ашгийг хэвээр хадгалахын тулд дахин давхарлах (жил бүр) шаардлагатай болдог. Иймэрхүү газруудыг хүн тогтмол очиж шалгасан байх хэрэгтэй (урьдчилан сэргийлэх явцад эсвэл байнгын ашиглалтын дүрэм гэх мэт).

Газрын гадаргууг зохицуулах

Ургамлын менежмент

Бүх аэродромд ургамалжсан талбай байдаг, эдгээр нь шувуудын анхаарлыг татах, нэн түрүүнд идэш тэжээлийн гол хүчин зүйл болдог. Мөн сэлгүүцэх, зарим тохиолдолд үүрлэх хүчин зүйл болно.

Ургамлын менежментийн хамгийн оновчтой арга техник нь асуудал болж буй шувууны зүйлээс хамаардаг.

Та ургамал ургах орчны хөрсний хэлбэр, цаг уур зэргийг тодорхойлосон байх хэрэгтэй. Тариалж буй ургамлын хэлбэр нь менежментийн арга техник болон хүрээлэн буй орчинтойгоо хамгийн сайн зохицсон байх хэрэгтэй.

Хог ургамал нь хоол хүнсээр хангаж, шувууд амрах боломжтой сийрэг ургамалжилт үүсгэдэг. Иймээс нягт шигүү бүрхэцтэй зүлэг тохиромжтой байдаг.

Ийм тохиолдолд та цаг уурт нөлөөлж чадахгүй учир хөрсийг өөрчлөх (бордоо хэрэглэх гэх мэт) хэрэгтэй. Зүлгийг сонгохдоо зүлэгний менежментийн талаар орон нутгийн тариалангчид, үр худалдаалагчид, орон нутгийн цэцэрлэгт хүрээлэнгийн удирдлагууд болон мэргэжилтнүүд, ургамал хамгаалагчид, эсвэл судлаачдаас зөвлөгөө авах хэрэгтэй.

Зүлэг тарихад хадах, хог ургамлаас сэргийлэх цацлага болон бордоо, хортонтой тэмцэх бодисын хэрэглээнд тогтмол анхаарал хандуулах шаардлагатай болдог.

Гэхдээ энэ хичээл зүтгэл нь шувуу хянах урт хугацааны амжилттай шийдлийн эцэст үр дүн үзүүлдэг.

Ургамлын хамгийн тохиромжтой өндөр нь зорилтот зүйл шувуунаас хамаардаг. Богино ба өндөр ургамлын менежментийн арга техникууд аль аль нь давуу ба сул талуудтай.

Өндөр өвсний арга техник

Аливаа аюултай, эсвэл махчин амьтан ойртож байгааг харж чадахуйц задгай газрыг шүтэн амьдардаг шувуудыг мохоож саатуулахад өндөр өвсийг ашигладаг. Гэхдээ үүнийг ихэнх шувуудын хувьд, ялангуяа хавтгаалж (spur-winged plover) болон цахлайн (black-backed gull) хувьд ашигладаг.

Өвс нягт ургадаг байх нь саатуулалтыг хамгийн үр дүнтэй болгоно. Өвсийг хавраас өмнө богинохон болгож тайраад, бордоо хэрэглэх нь хаврын ургалтын явцад ашиг шимийг хамгийн өндөр байлгахын зэрэгцээ өвсний нягт ургалтыг дэмжинэ.

Өвс ойролцоогоор 30-40 см өндөртэй байх нь тохиромжтой, гэхдээ газар дээгүүр сүрэлний нөлөө үзүүлэх өтгөн саглагар байж болохгүй, зорилгод сөргөөр нөлөөлнө.

Үр үүсэх нь шувуудын анхаарлыг татах тул хүлээн зөвшөөрч болохгүй.

Өвс нь ил харааны навигацийн төхөөрөмж, эсвэл тэмдэгт саад болохгүй байхад анхаарах хэрэгтэй.

Өндөр өвс нь хавтгаалж мэтийн томоохон шувуудыг тухайн газарт хооллох, суухад саад болно. Өндөр өвс үрлэж эхлээгүй тохиолдолд тодол, боршувуу, божирго, болжмор зэрэг жижиг шувууд тэмүүлдэггүй. Гэхдээ галуу, ангир зэрэг шувууд өвсөнд, ялангуяа үр тариа, вандуй, овьёос үрлэх үед хооллодог тул тариалж болохгүй. Тэд ялангуяа шинээр ургаж буй ургамалд татагддаг.

Нугас, цахлай гэх мэт шувууд мөн өндөр өвсөнд үүрлэдэг.

Өндөр өвс мэрэгчдийн анхаарлыг мөн л татдаг. Мэрэгчид нь сар, шонхор гэх мэт бусад шувуудын хувьд идэш тэжээлийн таатай нөхцөл болохгүй гэдгийг, эсвэл өөрсдөө аюул болохгүй гэдгийг бататгах мониторинг судалгаа хийлгэх шаардлагатай.

Богино өвсний арга техник

Мэрэгчид болон өндөр өвсөнд орогнодог, эсвэл биеэ хамгаалдаг бусад шувуу, амьдтыг зайлуулахдаа богино өвсийг ашигладаг.

Жижиг шувууд болон мэрэгч амьдтыг зайлуулах өвсний өндрийн тохиромжтой хэмжээ ойролцоогоор 15-20 см байдаг.

Энэ арга нь томоохон шувуудын хувьд суух, хооллох тааламжтай орчныг бүрдүүлдэг сул талтай.

Урт ба богино өвсний хослосон арга техник

Зарим аэродромууд урт ба богино өвсний хослосон аргыг нэвтрүүлээд байна. Хөөрч буух зурвас болон явгалах замын орчимд өндөр өвс, харин түүний гадна талаар богино өвс ургуулж байна.

Өндөр өвсийг ойролцоогоор 1-2 м өргөн зурвасаар хөөрч буух зурваст тохиромжтой

өнцгөөр ургуулж, өндөр өвс бүхий зурвас хооронд ойролцоогоор 20 м богино өвс тарих өөр арга туршигдаж байна.

Энэ аргын зорилго нь шувууд богино өвсөнд байхдаа ойртон ирж буй аюул, эсвэл махчдыг харж чадахгүй болгох явдал байв. Иймээс шувууд талбайгаас холдсон.

Гэхдээ өвс харааны хязгаарыг тохиромжтой төвшинд хангах хангалттай өндөр, эсвэл нягт ургаж чаддаггүй. Тиймээс зөв өвсийг сонгосноор энэ арга техник ажиллх болно.

Мод тарих

Шувуудын амьдрах орчныг өөрчлөх өөр нэг арга зам нь шувуудын ашиглаж буй талбайг моджуулах явдал юм.

Нэг зүйл цахлайнууд үржлийн нутгаасаа нисэх, хооллох нутгаасаа эргэн ирэхдээ өдөр бүр нислэгийн бүсийг хөндлөн гарч нисдэг байв. Энэ тохиолдолд орчны өөрчлөлтийг аэродром дээр хийгээгүй. Шувуудад саад үүсгэх үүднээс үүрлэхэд тохиромжтой тухай газарт урт хугацааны төлөвлөгөөний явцад мод ургуулсан. Ингэснээр тухайн шувуудын үүрлэх боломжтой талбай багасч, шилжин явсан.

Идэвхтэй менежментийн арга техник

Идэвхтэй менежментийн арга техник нь шувуудын амьдрах орчныг өөрчилдөггүй, шувуудыг үргээх (дүрст үзүүлэн, дуу чимээний үргээгч гэх мэт), эсвэл зайлуулахад (устгах, шилжүүлэн тавих) чиглэдэг.

Хэрэв шувуудын томоохон сүрэг аэродромд илэрч, тэдгээрийг аэродромоос амжилттай үргээн зайлуулж чадахгүй бол аэродром эзэмшигч нь нисэх багт боломжит аюулын талаар NOTAM-аар мэдээллэх хэрэгтэй.

Үргээх арга техник

Үргээх төхөөрөмжийг байнга, эсвэл цөөн хэрэглэвэл шувууд хурдан дасал болдог. Тиймээс үргээх төхөөрөмжийг оновчтой хэрэглэх, үргээгчийн байршлыг тогтмол өөрчлөх, үйлчилгээ нь санамсаргүй сонголттой байх нь чухал. Үргээх төхөөрөмжийг зайлуулах аргатай хослуулан хэрэглэвэл шувууд төхөөрөмжөөс болгоомжилсоор байх болно.

Нүүдлийн шувууд нь түр зуурын шинж чанартай учраас нэмэлт тархалтын асуудал үүсгэдэг. Тэдний нислэгийн чиглэл, хэв маягийг нарийн судлах шаардлагатай. Энэ мэдээлэл нь Монгол улсын Нислэгийн Мэдээллийн Эмхэтгэлд хэвлэгдсэн, эсвэл агаарын тээвэрлэгч байгууллагуудад шууд мэдээлэгдсэн байх хэрэгтэй.

Дүрс, үзүүлэн маягийн үргээх төхөөрөмж /Visual deterrents/

Аэродромд байрлуулсан дүрс, үзүүлэн маягийн үргээх төхөөрөмжүүд нь шувуудад таагүй байдал үүсгэж, улмаар тэд тухай газрыг орхин холддог.

Цаасан шувуу

Цаасан шувууд, ялангуяа махчин шувууны хэлбэртэй цаасан шувууд нь шувуудыг үргээхэд сайн үр дүнтэй байдаг. Энэ нь жижиг шувуудын эсрэг илүү үр дүнтэй. Эдгээр хэрэгслүүд нь сайн аргамжигдсан, агаарын хөлөгт аюул учруулахааргүй байх нь чухал.

Дуураймал биет

Махчин шувууны дуураймал биетүүдийг жижиг шувуудын нөлөөллийг хязгаарлахад ашигладаг.

Гялбуулах хэрэгслүүд

Гялбах хэрэгслүүд нь шувуудыг сарниулах үр дүнтэй (саа, цахилгаанжуулсан хашлага, гялалзсан гадаргуутай эргэлдэгч биетүүд гэх мэт).

Энэ төрлийн хэрэгслүүдийг ашиглахдаа нисгэгчийг гялбуулахаас сэргийлэх хэрэгтэй.

Модонд дүүжлэх хэрэгслүүд

Муурны товгор нүд бүхий нүүрний металл хийцүүдийг мод, буанд өлгөх нь жижиг шувууд хоноглох, үүрлэхээс сэргийлэх үр дүнтэй.

Эргүүл

Шувууд бөөгнөрсөн газарт эргүүл хийхдээ машин болон хүн ашигладаг.

Хэрэв шувууд машинд дасал болсон бол түүний нөлөөллийн гадна талд үргэлгүйгээр үлдэнэ.

Нохой

Ноход, ялангуяа шувуу үргээхээр сургагдсан ноход АНУ-д үр дүнтэй ашиглагдаж байна.

Ноходын тохиромжтойг нь шилж, цэргийн болон иргэний аэродромд сургадаг, тиймээс тэд төрөл бүрийн агаарын хөлгийн орчимд ажиллахад дассан байдаг.

Гэсэн хэдий ч ноход нь аюул учруулахгүй байхын тулд дээд зэргийн дасгал сургуулилт хийлгэж сэрэмжлэх хэрэгтэй.

Ноход агаарын хөлгийн үйл ажиллагаа явагдаагүй үед маш сайн ашиглагддаг.

Пиротехникүүд

Пиротехникүүд нь хурц гэрэл, тэсрэх чимээ гаргадаг дүрс болон дуу чимээний үр дүнтэй үргээгч төхөөрөмж юм. Бусад үргээх хэрэгслийн адил хэт их ашиглавал тэдний үр ашиг буурна.

Bird Frite гэх мэт пиротехникийн сум (cartridge) нь үрлэн сумт буу (shotgun) ашигладаг.

Ашиглагчид нь түүнийг хэрэглэх талаар зохистой сургалтад хамрагдсан байх шаардлагатай.

Хөдөлгөөнт бүсийн орчимд пиротехникийн хэрэгслийг ашиглах үедээ аюулгүйн санамжийг мөрдөх хэрэгтэй.

Агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд үл ойлголцол гарахгүйг бататгах үүднээс нислэгийн хөдөлгөөний удирдлагын нэгжтэй харилцан уялдаатай ажиллах хэрэгтэй.

Дуу чимээний үргээх хэрэгслүүд

Дуу чимээний үргээх хэрэгслүүд нь шувуудын сонсголд дарамт учруулахыг зорьдог.

Хэт авианы багаж

Хэт авианы багажууд нь хүний сонсголын хүрээнээс дээш дуу чимээг дамжуулж, шувуудад дарамт учруулдаг.

Тэдгээр нь гол төлөв ангар дотор үр дүнтэй хэрэглэгддэг,

Шувуудын тарчлаант ба махчин шувуудын дуу

Шувуудын тарчлаант дууг чанга яригчаар дуугаргах нь зорилтот онцгой шувуудад үр дүнтэй хэрэглэгддэг. Махчин шувуудын дууг дуугаргах нь жижиг шувуудын эсрэг ялимгүй нөлөөлдөг.

Гэхдээ тарчлаант дууг дуугаргахад зарим шувууд (шаазгай гэх мэт) өөрсдийн ижил зүйл шувууны дуунд татагддаг тул болгоомжлох хэрэгтэй. Шувууд сарниж холдох болон тухайн газарт шувууд нэмэгдэж ирэхгүй гэдгийг бататгах үүднээс мэргэжилтний туслалцаа авах хэрэгтэй.

Пиротехникүүд

Дээр дурдсанаар, пиротехникүүд нь харааны болон дуу чимээний үр дүнтэй үргээгч хэрэгсэл юм.

Зайлуулах арга техник

Зайлуулах арга техник нь устгах болон өөр газарт шилжүүлэн байршуулах аргыг агуулдаг. Гэвч удирдлага шувуудыг алах, эсвэл үргээж зайлуулахыг ихэвчлэн шаарддаг.

Хамгаалагдсан зүйлүүд

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Байгаль орчныг хамгаалах тухай 1995 оны хууль нь байгаль орчны хамгаалал, зохистой ашиглалт болон хяналтыг зохицуулдаг. Энэ нь шувуудын хамгааллын зэрэглэл, бусад зүйлсийг агуулдаг. Монгол орны шувууд нь хууль тогтоомжийн хуваарьт зааснаас бусад тохиолдолд хамгаалагдсан болно. Аэродромын шувуудыг хянахтай холбогдсон хуваарь дараах байдалтай байна:

- Хуваарь 1 - Агнуурын амьтан
- Хуваарь 2 - Хэсэгчлэн хамгаалагдсан амьтан
- Хуваарь 3 - Засгийн газрын зөвшөөрлөөр агнаж болох амьтан

Тус хуулийг <http://www.legalinfo.mn/> сайтаас харах боломжтой.

Аэродромын хувьд асуудал үүсгэж буй олон зүйл шувуу, зэрлэг амьтад Хуулиар хамгаалагдсан байдаг. Өвөгт тогируу, сохор элээ, хар хэрээ, шилийн сар гэх мэт шувууд нь жагсаалтад ороогүй боловч хамгаалагдсан. Зарим нугас, галуу, дагуур ятуу

зэрэг нь агнуурын шувуудын жагсаалтад орсон. Гэхдээ аэродром дахь хуулиар хамгаалагдсан аливаа шувууг устгахаас өмнө өсөлтийн үе шатнаас нь үл хамааран (хөврөл, ангаахай, эсвэл бие гүйцсэн) эрх бүхий газраас зөвшөөрөл гаргуулах нь чухал.

Эрх бүхий байгууллага

Таны хянахыг зорьж буй хамгаалагдсан шувуудыг алах, эсвэл үргээж зайлуулах зөвшөөрлийг Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яамнаас гаргана.

Ийм зөвшөөрөл нь нөхцөл байдлаас хамаарна. Хамгаалагдсан зүйлийг алахаас өмнө боломжтой бүх аргыг ашиглах оролдлогуудыг хийсэн байхыг шаарддаг бөгөөд зөвхөн агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй тохиолдолд алах нь зөвшөөрөгддөг. Алагдсан шувуудын тоог хамгийн бага байлгах ёстой. Хөл, далавч, хүзүүндээ тэмдэг бүхий шувуу алагдсан бол дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль хамгаалах хэлтэст илгээнэ. Аливаа түгээмэл бус тохиолдох зүйл алагдсан тохиолдолд хөлдөөж, Байгаль хамгаалах хэлтсээс шаардлагатай мэдэгдлийг хүлээж ав.

Энэ зөвшөөрлийг өгөх үед бүртгэлийг үнэн зөв хөтлөнө. Та Байгаль хамгаалах хэлтэст жил бүр нарийвчилсан мэдээллийг илгээж байх хэрэгтэй.

Шилжүүлэх

Ховордсон, эсвэл бусад онцгой ач холбогдол бүхий хамгаалагдсан шувуудыг барьж аэродромоос шилжүүлэн тавих асуудлыг анхаарах хэрэгтэй.

Барих, эсвэл тор тавихдаа Байгаль хамгаалах хэлтэс, орон нутгийн амьтан хамгаалах байгууллага, эсвэл шувуу судлаач мэргэжилтнээс туслалцаа авах боломжтой. Шувуу баригч биет нь тухайн шувуунд дарамт болон хор хөнөөл хамгийн багатай байх хэрэгтэй. Нэг сул тал гэвэл ихэнх шувууд нутагтаа буцаж ирэх хүчтэй зан төрхтэй байдаг бөгөөд баригдсан газартаа богино хугацааны дотор буцан ирэх чадвартай. Мэргэжилтний зааврыг хайж ол. Гэхдээ хамгаалагдаагүй, эсвэл ховордоогүй шаазгайг өөр газар нутагт тавих нь амжилттай болж байгаа. Гэвч шаазгайг барих, торонд хийхэд тарчлаант дуу авиа гаргаж бусад шаазгайн анхаарлыг татдаг тул болгоомжлох хэрэгтэй.

Өндөг ба ангаахайг онилох

Өндөг

Шувуудын үүрийг хайн олж, өндгийг устгах нь тухайн зүйлийн популяцийг бууруулдаг. Энэ нь үржлийн шувууд болон агаар дахь залуу шувуудын тоо толгойг бууруулах урт хугацааны үр дүнтэй арга юм. Тухайн газар дахь үржил үргэлжилэн амжилтгүй байснаар зарим зүйл шувууд тус газрыг орхидог.

Гэвч шувуудын хариу үйлдэл зүйл бүрд харилцан адилгүй. Хар хэрээ, Сохор элээ, Өвөгт тогоруу зэрэг шувуудын нэг өндгийг гэмтээх, эсвэл авсан байхад үргэлжлүүлэн өндөглөсөөр байдаг. Энэ маягаар өндгийг гэмтээх нь тухайн шувуудын үржлийн улирлыг хойшлуулдаг. Харин Хээрийн бүргэд зэрэг зарим шувууд үүрээ орхих нь

түгээмэл.

Тухайн хяналтын аргыг хэрэгжүүлэхдээ мэргэжилтний туслалцааг авах хэрэгтэй. Мөн шингэн уусмалаар тарьж будах аргыг өргөн хэрэглэдэг. Ингэснээр хэн нэгэн өндгийг авч хагалах үед хүнсэнд хэрэглэж болохгүй гэдэг нь илэрхий болно.

Зарим аэродромууд газар дээр үүрлэсэн шувууны өндгийг устгах механик аргыг ашигладаг. Машинаар борной, бул, тэгшлэгч, эсвэл төмөр замын төмөр, дугуй зэргийг чирэх нь үр дүндтэй байдаг. Гэхдээ гэрэлтүүлэг, тэмдэг зэрэг аэродромын бусад байгууламжуудыг гэмтээхгүй байхад анхаарах хэрэгтэй.

Дэгдээхэй/ангаахай

Ангаахай/дэгдээхэйг үүрэнд нь устгах, эсвэл шилжүүлэх боломжтой.

Залуу шувууд, ялангуяа цахлай, нугас, хавтгаалжийн залуу шувуудын хувьд бие гүйцэсэн шувуудтай харьцуулахад нисэх үедээ агаарын хөлгийн аюулаас сэргийлэх сэрэмж, түргэн шаламгай байдал, урьдчилан таамаглах чадвар хөгжөөгүй байдаг тул агаарын хөлөгт аюул учруулах боломж нэмэгддэг.

Зорилтот залуу шувуудыг буудах нь эрсдэлийг бууруулна.

Устгал

Аливаа шувууны аюулын хамгийн тогтмол шийдэл нь тухайн асуудал үүсгэж буй шувуудыг буудах, эсвэл шууд ба шууд бусаар хордуулах (идэш тэжээлээр гэх мэт) зэргээр устгах явдал юм.

Буудах

Шувууг буудах нь үргэлж хялбар байдаггүй. Шувууд улам хянамгай болох, онцгой машинтай буудагчдыг нүдлэн таних, аюултай бүсийн гадна байрлах зэргээр ойртоход хүндрэл үүсгэдэг.

Зарим аэродромууд хэд хэдэн төрлийн аргыг ашиглан хэрэгжилтийг сайжруулж байна. Шувуудыг гуужилтын үед нь, эсвэл газар дээр олноор цугласан үед нь нисдэг тэрэгнээс буудах зэргээр шувууны анчдыг ашиглах нь үр дүнтэй.

Галт зэвсэг ашиглах, ялангуяа аэродром, түүний орчимд буудахдаа онцгой анхааралтай байх хэрэгтэй.

Хордуулах

Асуудал таригч шувуудыг цөөлөх өөр нэг арга нь хордуулах юм. Олон тооны, эсвэл тухайлсан шувуудыг устгахад Альфахлоралоз хамгийн үр дүнтэй гэж үздэг.

Хорыг хэрэглэхийн тулд хамгийн тохиромжтой байрлал, аргыг тодорхойлох үүднээс шувууны судалгаа хийх хэрэгтэй.

Идэш тэжээлтэй хамт хэрэглэх, мөн өгөөш авах боломжийг туршиж мэдэх хэрэгтэй. Үхсэн шувуудын газарзүйн цар хүрээг багасгах үүднээс өдрийн өөр өөр цагуудад хооллох шаардлага гарч болзошгүй. Шувуудыг орой хоноглох, эсвэл үүрлэж буй газар руугаа явахын өмнө нь хооллох нь үр дүнтэй байж болзошгүй.

Ингэхдээ зорилтот бус зүйл шувуудын хорогдлыг бууруулах төлөвлөгөө байх шаардлагатай. Энэ арга тагтаа, тодол, нугас зэрэг шувуудад үр дүнтэй нь

ТОГТООГДСОН.

Хамтын ажиллагаа

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөр нь түүнийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх бүх талууд оролцсон байх нь хамгийн үр дүнтэй.

Мэргэжилтний туслалцаа

Шувуу судлаачид нь шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийг хөгжүүлэхэд туслах зөвлөх үйлчилгээгээр хангана (Зарим нь зэрлэг амьтны аюулаас сэргийлэх менежментээр мэргэшдэг). Орон нутгийн шувуу судлаачид экологийн болон шувуудын талаар зөвлөгөө өгч, тоо толгойн судалгаа хийх боломжтой. Шувуу судлаачидтай Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг, Ш/Х 537, Улаанбаатар 210646, эсвэл info@mos.mn, www.mos.mn хаягаар холбоо барьж болно. Байгаль орчны, эсвэл их дээд сургуулиудын судлаач нар аэродромын хөрс, ургамал, шувуудын идэш тэжээлийн нөөцийн зохицуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Хортон шавьж устгах байгууллагууд нь жижиг шувуудын зүйл, ялангуяа барилга байгууламжийн орчмын шувуудад чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг.

Орон нутгийн удирдлагууд

Орон нутгийн удирдлагууд нь хуулиар тогтоосон эрх мэдлийн хүрээнд хаягдал ус цэвэрлэх байгууламж, хогийн цэг, цэцэрлэгт хүрээлэн, спортын болон амралт зугаалгын газруудын төлөвлөлтийг хариуцдаг.

Орон нутгийн удирдлагуудад аюулын тухай, мөн газар ашиглалтын хязгаарлалт болон аэродромын орчмын шувуудыг бууруулах менежментийг хөгжүүлэх талаар мэдэгдсэн байх хэрэгтэй.

Байгаль хамгаалах газар

Орон нутгийн Байгаль орчны хамгааллын газар нь тухайн бүс нутгийн амьтан ургамлын хамгаалал, зохион байгуулалтыг хариуцдаг. Тус байгууллагын ажилтан нь төвөг учруулж буй хамгаалагдсан зүйл амьтдыг үргээх, эсвэл устгах зөвшөөрөл олгох бөгөөд тухайн зүйлийн талаар мэдээллээр (амьдрах орчин, идэш тэжээл, популяци, тоо толгой, хяналтын арга гэх мэт) хангана. Мөн экологийн судалгаанд туслах боломжтой. Байгаль хамгаалах газар нь асуудал үүсгэгч шувууд тухайлбал, элээ, тогоруу, нугас, хэрээ зэргийг бууруулах, өөр газарт шилжүүлэх зэрэгт аэродром эзэмшигчидтэй хамтран ажиллана.

Сонирхогч талууд

Бусад сонирхогч талууд харилцан ашигтай байгаа тохиолдолд туслахад бэлэн байдаг. Жишээлбэл, Монголын Шувуу Судлалын Нийгэмлэг болон бусад байгаль орчны нийгэмлэгүүд экологийн судалгаа, зүйлийг таньж тодорхойлох болон популяцийг тоолох зэрэгт, Их, Дээд сургуулиуд шувуу, амьтдын зан төрх, хөрс, ургамлын судалгаа, эсвэл менежментийн чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Төгсөгч оюутнууд шувууны аюулын менежментийн хөтөлбөртэй холбоотой бие даасан хээрийн судалгаа хийх болон аэродром эзэмшигчидтэй шинэ техник технологийн талаар мэдээлэл солилцоход бэлэн байдаг.

Харилцаа холбоо ба хэвлэл мэдээлэл

Харилцаа холбоо нь аливаа шувууны аюулыг бууруулах менежментийн хөтөлбөрт томоохон үүрэг гүйцэтгэдэг. Ялангуяа хяналтын хөтөлбөрийг аэродромын хилийн цаана хэрэгжүүлэх гэж байгаа тохиолдолд энэ нь тухайн зүйлийн популяцийг бууруулах чиглэдэг.

Шувууны тоо толгойг бууруулах ажиллагаанд олон нийт ихэвчлэн нааштайгаар ханддаггүй. Тиймээс хэвлэл мэдээллийг хянуур эрхлэх хэрэгтэй. Сөрөг нийтлэлийг багасгахын тулд хөтөлбөрийн аюулгүй байдал болон хэрэгжүүлж буй арга хэмжээ сонголтыг онцгойлон анхаарах хэрэгтэй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө, эсвэл хэрэгжүүлсний дараа илүү сайн болох эсэхийг сайтар эрэгцүүл.

Салбарын сөрөг нөлөөллийг багасгахын тулд харилцаа холбооны мэргэжилтнүүдийг ашиглах талаар бодолц.

Заримдаа орон нутгийн удирдлагууд хяналтын хөтөлбөрийн талаар орон нутгийн сонинд мэдээлэл байршуулах, мэдээлэх хуудас тараах, эсвэл стратегийн байрлалуудад олон нийтэд зориулсан анхааруулах тэмдэг байрлуулахыг шаардана. Хэрэв шаардлагатай бол холбоо барих хүний нэр, утасны дугаарыг зарлал, мэдээлэх хуудсанд байрлуулах хэрэгтэй. Ингэснээр олон нийт лавлагаа мэдээллээ тухайн хүнээс тогтмол авах боломжтой болно.

Бусад мэдээллийн эх үүсвэр

Шувууны аюулаас сэргийлэх менежментийн хөтөлбөрийг хөгжүүлэхэд мэдээлэл хамгийн чухал. Бүх аэродром эзэмшигчид ижил төрлийн асуудлуудаа хуваалцдаг. Шинэ арга техникээс хоцрохгүй байх, асуудалтай шувуудын талаар туршлага солилцоходоо бусад аэродромуудтай хамтран ажилладаг. Нэмж хэлэхэд Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага Шувуунд тавих хяналт ба бууруулалт хэмээх *Нисэх Буудлын Үйлчилгээний Гарын Авлага* (Doc 9137-AN/878) хэвлүүлсэн, үүнийг Иргэний Нисэхийн Ерөнхий Газраас авах боломжтой.

Нарийвчилсан мэдээллийг интернэтээс олох боломжтой. Ялангуяа аэродром эзэмшигч нарт зориулан Канад улсын Тээврийн яамнаас (Канадын иргэний нисэхийн асуудлыг хариуцагч) эрхлэн гаргасан шувууны аюулаас сэргийлэх

менежментийн цогц баримт бичиг нь тун сайн эх сурвалж болдог. Үүнийг Transport Canada's *Sharing the Skies: An Aviation Industry Guide to the Management of Wildlife Hazards*, эсвэл *Wildlife Control Procedures Manual* гэж бичиж интернэтээс татах, эсвэл <http://www.tc.gc.ca/en/menu.htm>. хаягнаас бусад баримт бичгүүдийг татан авах боломжтой. Бусад ижил төстэй байгууллагууд мөн холбогдох сэдвээр нийтэлсэн байдаг.

Монгол орны шувуудын талаарх номуудыг номын дэлгүүр, эсвэл номын сангаас авах боломжтой ба танд шувуудыг таньж мэдэх, амьдрах орчин болон идэш тэжээлийн талаар илүү дэлгэрэнгүй ойлгоход туслана. UK CAP 680, US Department of Agriculture - Wildlife Hazard Management at Airports (Richard Dolbeer and Ed Cleary) хэмээх гарын авлагыг судлаарай.

Хавсралт - 1

Онцгой зүйлүүд - Таних шинж ба хяналтын аргууд

Асуудал үүсгэдэг түгээмэл 15 зүйл шувууны ерөнхий шинж, статус (хамгаалагдсан, хамгаалагдаагүй, эсвэл агнуурын) болон бие гүйцсэн, залуу шувуудыг таних арга, үржил, үүрлэх орчин, бусад онцлогууд болон тэдгээрийг хянахад зориулсан хамгийн үр дүнтэй аргуудын талаар товч бичлээ. Үүнд:

- Хондон ангир
- Зэрлэг нугас
- Сохор элээ
- Нөмрөг тас
- Идлэг шонхор
- Начин шонхор
- Дагуур ятуу
- Өвөгт тогируу
- Хөхвөр тагтаа
- Боршувууны багийн зарим жижиг шувууд (Шоорон эвэртболжмор, Монгол болжмор, Дэрсний жиргэмэл)
- Бор тодол
- Алаг шаазгай
- Улаанхушуут жунгаа
- Түрлиах хэрээ
- Хар хэрээ

Хондон ангир

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Монгол оронд үрждэг, дайрч өнгөрдөг, өвөлждөг, нүүдлийн зүйл. Монгол орны бараг бүхий л усан санд түгээмэл тохиолдоно.

Таних шинж - Бие гүйцсэн

- Их бие улбар шар, толгой цайвар
- Хушуу- хар
- Хөл- хар
- Биеийн өндөр- 58-70 см

Эр

- Бие гүйцсэн шувууны хүзүү бөгж маягийн хар судалтай

Эм

- Толгой- цайвар

Таних шинж - Залуу шувуу

- Толгой- цайвар бор шаргал
- Биеийн дээд хэсэг- цайвар бор хүрэн.
- Биеийн доод хэсэг- улбар шар
- Бие гүйцсэн шувуутай төстэй

Үржил ба үүрлэх орчин

- Үржлийн улирал 4 дүгээр сарын сүүлчээс 5 дугаар сарын эхэнд эхэлж, 8 дугаар сар хүртэл үргэлжилнэ.
- Усан сан, нуур, голын ойролцоо далд байдлаар нүхэнд, эсвэл модны хонгилд үүрлэдэг.
- Цагаан өнгийн 8-12 өндөг гаргана.

Бусад онцлог шинж

- Чийглэг нуга, намаг, ус намгархаг газарт усны ургамал болон хуурай газрын ногоон ургамлаар хооллоно.
- Мөн шавьж, загас, мэлхий, өт хорхойгоор хооллоно.
- Ихэвчлэн нуур, усан сангийн орчимд зуны сүүлчээр гуужих үедээ сүрэглэдэг.
- Гуужих үеэрээ нисэх чадвараа алддаг.
- Томоохон нуур ба тариан талбайд 20-8000 шувууд цуглаж том хэмжээний сүрэг үүсгэдэг.
- Хөлдөөгүй нуур болон голуудаар цөөн шувууд өвөлждөг.

Зүйлийг хянах аргууд

- Өндөр өвсний менежментийн арга техникийг ашиглах ба ургамлын хэлбэрийг анхааралтай сонгох

- Хөдөлгөөнт бүсийн зүлэгжүүлсэн гадаргууд вермицид болон пестицид хэрэглэх, пиротехник (bird frite гэх мэт) болон буу ашиглах.
- Усан сан, ус зайлуулах сувгийн дээгүүр торлох

Зэрлэг нугас

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үржлийн, дайрч өнгөрдөг, мөн өвөлждөг. Монгол орны бараг бүх хэсэгт тохиолдоно.

Таних шинж - Бие гүйцсэн

- Шинж тэмдэгийн хувьд бодгалийн хувьсал ихтэй
- Биеийн өндөр- 50-60 см.

Эр бодгалийн үржлийн үеийн өдөн бүрхэвч

- Толгой- цагаан хүзүүвч бүхий гялалзсан ногоон.
- Цээж- улаан хүрэн.
- Хэвлий - судал бүхий мөнгөлөг.
- Далавч -цагаан хөвөө бүхий тод цэнхэр толботой, саарал.
- Нүд - бараан хүрэн.
- Хушуу - шаргал ногоон.
- Хөл - улбар шар.

Эр бодгалийн үржлийн бус үеийн өдөн бүрхэвч (зуны сүүлч, намар)

- Эм шувуутай адил, гэхдээ шувуу оливын ногоон.

Эм

- Эрүү, хоолой болон хүзүүний урд хэсэг- цайвар бор шаргал.
- Биеийн дээд хэсэг- цайвар судал, толбо бүхий хүрэн.
- Нүд- бараан судалтай.
- Далавч- эрийнхтэй ижил.
- Хушуу- улбар-хүрэн
- Хөл- Улбар шар

Таних шинж - Залуу шувуу

Дэгдээхэй (хоёроос гурван долоо хоногтой)

- Хардуу хүрэн.
- Нүүр- Шар.
- Нүд- Бараан судалтай

Залуу шувуу

- Нүд-Бие гүйцсэн эмийнхтэй ижил боловч арай бүдэг.

Үржих болон үүрлэх орчин

- Дөрвөөс зургадугаар сард үржинэ.
- Усны ойролцоох саглагар ургамал, бутны ёроолд, эсвэл модны хонгил, барилга байгууламжид үүрлэнэ.
- Цайвар бор толбо бүхий цагаан өнгийн дунджаар 12 өндөг гаргана.

Бусад онцлог шинж

- Ургамал, эсвэл жижиг шавьж, гол төлөв усны сээрнууруугүйтэн, боловсорсон үрээр хооллодог.

Зүйлийг хянах аргууд

- Үржлийн улирлын туршид богино ургамлын менежментийн арга техникийг ашиглах
- Хөдөлгөөнт бүсийн ургамалжсан талбайд хортон шавьж устгах бодис хэрэглэх
- Пиротехник (Bird frite гэх мэт) болон ангийн буу хэрэглэх
- Усан сан, үерийн усны шуудууны дээгүүр торлох

Сохор элээ

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй
Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үржлийн, дайрч өнгөрдөг. Монгол орны бараг бүх хэсэгт тохиолдоно.

Таних шинж - Бие гүйцсэн

- Биеийн дээд хээсэг - бараан хүрэн.
- Биеийн доод хээсэг - Цайвар шаргалдуу хүрэн
- Нүдний хүрээ - саарал.
- Нүд - цайвар хүрэн.
- Хушуу - бараан.
- Хөл - шар.
- Хумс - бараан.
- Биеийн өндөр - 55-68 см.

Хөгшин эр шувуу

- Далавч - гол төлөв бараан хүрэн.

Таних шинж - Залуу шувуу

Ангаахай

- Биеийн доод хээсэг - бор саарал
- Хөл - шар.

Залуу шувуу

- Бие гүйцсэн шувуутай ижил боловч биеийн нуруу, далавчны дээд хээсэг цоохор.

Үржлийн хугацаа

- Ихэвчлэн голын хөндий, хот суурин газрын ойролцоо хад чулуу, хавцал болон модон дээр үүрлэнэ.
- 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэнд цагаан толбо бүхий улбар, эсвэл бор өнгийн 3-4 өндөг гаргана.

Бусад онцлог

- Махчин шувуу.
- Гол төлөв оготно, чичүүл, хулгана, зараа болон жижиг шувуудаар хооллохоос гадна хүний хоол хүнсний хаягдал, сэг зэмээр хооллоно.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн аргыг хэрэглэх.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх.
- Үхсэн амьтдыг зайлуулах, далдлах.
- Хог хаягдлын цэгүүдийн зохион байгуулалт, идэш тэжээлийн эх үүсвэрийг багасгахад орон нутгийн удирдах байгууллагын дэмжлэгийг авах.

Нөмрөг тас

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн үрждэг, зарим нь өвөлждөг зүйл. Монгол орон даяар тохиолдоно.

Таних шинж - бие гүйцсэн

- Бүрхүүл өд- бор хүрэн
- Нүдний хүрээ -ягаавтар
- Нүд - бараан хүрэн
- Хушуу- Хар, түүний уг хэсэг шар, зэтэр ягаавтар
- Хөл - ягаавтар хуруутай, цайвар саарал
- Биеийн өндөр- 100-120 см.

Таних шинж - залуу шувуу

Залуу шувуу

- Бие гүйцсэн шувуутай ижил боловч бүрхүүл өд нь бие гүйцсэн шувуутай харьцуулахад нилдээ хар, толгой болон хүзүүний ноолуурлаг өд хар.

Үржлийн хугацаа

- Уулын энгэрийн мод, хавцал, хадан дээр үүрлэнэ.
- Хатсан харгана болон бусад бутны иш, мөчрөөр том үүр засдаг.
- 3-р сарын эхэн үеэс 4-р сард сааралдуу толбо бүхий цагаан, эсвэл цайвардуу шаргал өнгийн 1 ширхэг өндөг гаргана.

Бусад онцлог

- Сэг зэмээр хооллодог.
- Сэг зэм дээр бусад тасын хамт цугладаг. Шинээр гарсан сэг дээр заримдаа 100 гаруй тоогоор цугладаг.

Зүйлийг хянах аргууд

- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх.
- Үхсэн амьтдыг зайлуулах, далдлах.
- Хог хаягдлын цэгүүдийн зохион байгуулалт, идэш тэжээлийн эх үүсвэрийг багасгахад орон нутгийн удирдах байгууллагын дэмжлэгийг авах.

Идлэг шонхор

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн, үрждэг, зарим нь өвөлждөг зүйл. Зөвхөн бие гүйцсэн бодгалиуд Монгол орны үлийн цагаан оготно, болжморын идэвхжил бүхий газарт өвөлждөг.

Таних шинж - бие гүйцсэн

- Бүрхүүл өд- өнгөний хувьд маш олон янз, толгой цайвар, шанаанд буй сахал мэт өд бүдэг, нарийн.
- Биеийн дээд буюу нуруун хэсэг- бор, улбар хүрэн, бараан хүрэн толбо бүхий саарал.
- Биеийн доод хэсэг төрөл бүрийн бараан толбо бүхий цагаан цайвар.
- Биеийн өндөр- 47-57 см.
- Эр нь эмээс биеэр жижиг, толбо судал багатай тул илүү цайвар харагдана.
- Хушуу- Бараан саарал, зэтэр шар.
- Хөл - тод шар.

Таних шинж - залуу шувуу

- Хушуу - бараан саарал, зэтэр шар.
- Хөл- хөхвөр саарал.

Үржил ба үүрлэх орчин

- Үржлийн улирал нь 4-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үе.
- Өөрөө үүр засдаггүй.
- Хон хэрээ, Шилийн сар, Тарважи бүргэд, Сохор элээ зэрэг шувуудын хад цохио, өндөр хүчдэлийн шон, мод, барилга байгууламж, элсэн эрэг дээрх хуучин, эсвэл шинээр зассан үүрийг ашигладаг.
- Бараан хүрэн толбо бүхий улбар хүрэн өнгийн 3-4 өндөг гаргана.

Бусад онцлог

- Шоорон эвэртболжмор, Дэрсний жиргэмэл, Монгол болжмор, үлийн цагаан оготно, чичүүл, огодой гэх мэт амьтдыг агнаж хооллодог.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн арга техникийг ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх.

Начин шонхор

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн, үрждэг, зарим нь өвөлждөг зүйл. Монгол орон даяар тархсан.

Таних шинж - бие гүйцсэн

Эр бодгаль

- Толгой- хөхвөр саарал.
- Сүүл- хөндлөн хар судлуудтай.
- Биеийн дээд хэсэг буюу нуруу- хар толбо ихтэй
- Нүдний хүрээ - шар
- Нүд - хар
- Хушуу- хар саарал, зэтэр шар.
- Хөл - тод шар.
- Биеийн өндөр- 27-35 см.

Эм бодгаль

- Толгой - зулай улбардуу шар.
- Биеийн дээд хэсэг буюу нуруу- улбар, толбо ихтэй.
- Сүүл- хөндлөн бараан судлуудтай.
- Эм бодгаль нь зээрд шонхорын эмтэй ижил боловч хумс нь хар байдгаараа ялгарна.

Таних шинж - залуу шувуу

- Эм бодгальтай ижил боловч биеийн доод хэсэг буюу цээж, хэвлий улбар хүрэн.
- Нүд - хар.
- Хушуу- бараан саарал, зэтэр тод шар.
- Хөл- шар.

Үржил ба үүрлэх орчин

- 5-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үед үрждэг.
- Хад асга болон хиймэл байгууламжийн нүх, завсар болон Хар хэрээ, Алаг шаазгай, Сохор элээ зэрэг бусад шувуудын зассан үүрэнд үүрлэнэ.
- Улаан хүрэн, ягаан толбо бүхий цайвар шаргал өнгийн 4-5 өндөг гаргана.

Бусад онцлог

- Үлийн цагаан оготно, царцаа, голио, жижиг шувуудын нисгэл ангаахайг агнаж хооллоно.
- Гол төлөв ганц тоогоор нисдэг.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн аргыг хэрэглэх.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх.

- Барилга байгууламжийн нүхний амсрыг торлох.

Дагуур ятуу

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Уулархаг бүс нутагт үрждэг, суурин зүйл. Элбэгшлийн хувьд манай орны хойд хэсэгт өмнөдөөс харьцангуй их.

Таних шинж - бие гүйцсэн

- Бүрхүүл өд- Улбар хүрэн.
- Хушуу- цайвраас хар саарал.
- Хөл- цайвар шар.
- Биеийн өндөр- 28-32 см.

Эр бодгаль

- Нүүр - Улбар.
- Биеийн дээд хэсэг буюу нуруу - Улбар хүрэн
- Биеийн доод хэсэг буюу хэвлий- үнсэн саарал бөгөөд “U” хэлбэрийн, том хар толботой.

Эм бодгаль

- Сахал болон цээжний хэсэг улбар.

Таних шинж - залуу шувуу

Бие гүйцсэн эм бодгальтай ижил боловч хэвлийдээ бараан толбогүй.

Үржил ба үүрлэх орчин

- Хад асга, бут сөөг бүхий уул, голын хөндийд үрждэг.
- 4-6-р сард үржинэ.
- Хадтай энгэрийн шигүү бут, өндөр өвсөн дунд газар дээр үүрлэнэ.
- Бараан толбо бүхий улбар, хүрэн, эсвэл ногоовтор өнгийн 8-15 өндөг гаргана.

Бусад онцлог

- Ангаахай 16-18 өдрийн дараагаас ниснэ.
- Ногоон ургамлын үр, үндэс, цэцэг, нахиа, шүүслэг навч болон бусад эд эрхтнээр хооллоно.
- Өвлийн улиралд нам дор газарт, цасны нимгэн хэсгээр идэш тэжээлийн олдоцыг даган сүрэглэн байршиж хооллоно.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн аргыг хэрэглэх.
- Ургамалжсан гадаргууд хортон, шавьж устгах бодис ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх., live shells.

- Популяцийн хэмжээг багасгах үүднээс буудаж цөөрүүлэх.

Өвөгт тогоруу/ өвөгт тогируу

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн, үрждэг, дайран өнгөрдөг зүйл.

Таних шинж - бие гүйцсэн

- Толгой - хар, зулай саарал.
- Хүзүү - хар, нүдний араас гарсан цацаг маягийн цагаан өдтэй.
- Бие - саарал.
- Нүдний хүрээ - цайвар саарал.
- Нүд - улаан.
- Хушуу- бараан саарал, үзүүр нь улаавтар хүрэн.
- Хөл - бараан саарал.
- Биеийн өндөр-80-100 см

Таних шинж - залуу шувуу

Дэгдээхэй

- Бие - шаргалдуу хүрэн бор.
- Толгой - шар.
- Нүд - хар.
- Хөл- саарал.

Залуу шувуу

- Бие гүйцсэн бодгальтай ижил боловч толгой, хүзүү бараан саарал, нүдний араас гарсан жижиг саарал өдтэй, биеийн дээд хэсгийн бүрхүүл өд сааралдуу бор.

Үржил ба үүрлэх орчин

- Жил бүр нэг газартаа 5-р сараас 6-р сард үрждэг.
- Ойт хээр, уулын хээр, цөлөрхөг хээр, тэгш талын тачир ургамалтай хэсэгт газар дээр үүрлэдэг.
- Бараан толбо, судал бүхий ногоовтор саарал, улбардуу бор өнгийн 2 өндөр гаргана.

Бусад онцлог

- Царцаа, чийгийн улаан хорхой, ургамлын үндэс, навч, нахиа болон цэцгээр хооллоно.
- Нүүдлийн үедээ тал хээрийн нуур, тариан талбайд 4000-8000 бодгаль бүхий том сүргүүд үүсгэдэг.

Зүйлийг хянах аргууд

- Өндөр ургамлын менежментийн аргыг ашиглах.
- Хөдөлгөөнт бүсийн ургамалжсан талбайд хортон шавьж, мэрэгч устгах бодис ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) ашиглах.

Хөхвөр тагтаа

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үрждэг, суурин зүйл.

Таних шинж - бие гүйцсэн

- Бүрхүүл өд - янз бүр.
- Хоолой, хүзүүний хэсэг - гялалзсан ногоон, ягаан.
- Чээж, хондлой - цайвар саарал.
- Нүд - улбардуу бор.
- Хушуу- бараан саарал.
- Хөл - улаан.
- Биеийн өндөр- 29-35 см.

Таних шинж - залуу шувуу

- Бие гүйцсэн бодгальтай ижил боловч бүрхүүл өд бүдэг, бор шаргал эмжээртэй.

Үржил ба үүрлэх орчин

- Барилга байгууламжийн булан тохой болон хаданд үүрлэнэ.
- Жилийн турш, ялангуяа хавар, зун үрждэг.
- Цагаан өнгийн 2 өндөг гаргадаг.

Бусад онцлог

- Нэгээс нөгөө газарт сүрэглэн нисдэг.
- Хөдөө орон нутгийн хувьд хоноглох ба хооллох газрын хооронд ихэвчлэн хол зам туулдаг.
- Ургамлын үр, буурцаг, чийгийн улаан хорхой, авгалдай, эмгэн хумс болон талхаар (хүний хаясан) голчлон хооллодог.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн аргыг ашиглах ба зүлэгний сонголтод анхаарах.
- Хөдөлгөөнт бүсийн зүлэгжүүлсэн талбайд хортон шавьж устгах бодис ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) болон ангийн буу ашиглах.
- Хордуулсан өгөөшөөр (Альфахлоралоз) хооллох.
- Барилга байгууламжийн булан тохойд өргөс байрлуулах, нүхийг тороор хаах.

Боршувууны багийн зарим жижиг шувууд (Шоорон эвэртболжмор, Монгол болжмор, Дэрсний жиргэмэл)

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Шоорон эвэртболжмор, Монгол болжмор нь манай орны үрждэг, суурин зүйл, Дэрсний жиргэмэл нь үрждэг, нүүдлийн зүйл бөгөөд заримдаа цөөн тоогоор өвөлжинө.

Тохиолдоц нь цаг уур, идэш тэжээлээс хамаарна.

Таних шинж - бие гүйцсэн

Шоорон эвэртболжмор

- Толгой- хар ба цагаан, зулайн хоёр талаар эвэр мэт нарийсан гарсан хар өдтэй.
- Биеийн дээд хэсэг буюу нуруу- ягаавтар бор.
- Биеийн доод хэсэг буюу хэвлий- цагаан.
- Биеийн өндөр- 14-17 см (бор шувуунаас арай том).
- Хушуу - хар.
- Хөл - бараан.
- Өвөлдөө сүрэглэдэг.

Монгол болжмор

- Толгой- цагаан, чээж хүрэн бор.
- Биеийн дээд хэсэг буюу нуруу - сааралдуу бор.
- Биеийн доод хэсэг буюу хэвлий - цагаан.
- Хушуу- шардуу.
- Хөл- улаандуу бор.
- Далавч - Хоёрдугаар зэргийн дэвэгч өднүүд цагаан ба хар. .
- Биеийн өндөр- 18-22 см (бусад болжморуудаасаа биеэр том)

Дэрсний жиргэмэл

- Биеийн дээд ба доод хэсэг - улбардуу бор.
- Хушуу- дээд хушуу бараан саарал, доодох нь шар.
- Хөл - бор.
- Биеийн өндөр- 13-14 см (Бор шувуунаас арай том).

Үржил ба үүрлэх орчин

- 3-5 өндөг гаргана.

Эвэрт болон Монгол болжмор

- Суур зүйл бөгөөд 5-6-р сард үрждэг.
- Өвсний ёроол болон намхан буны доор үүрлэнэ.

Дэрсний жиргэмэл

- Нүүдлийн шувууд 5—р сард үрждэг.

Бусад онцлог

Шоорон эвэртболжмор

- Ургамлын үндэс ба шавьжаар хооллоно.

- Өвлийн улиралд сүрэг үүсгэдэг.

Монгол болжмор

- Ургамлын үр, сээрнуруугүйтэн, шавьжт, түүний авгалдайгаар хооллоно.
- Өвөл сүрэглэдэг.

Дэрсний жиргэмэл

- Шавьж, сээрнуруугүйтэн, авгалдай, ургамлын үр, нахиагаар хооллоно.
- Намрын улиралд нүүдлийн болон өвөлжих бодгалиуд хуурай хээр, өндөр ургамал бүхий голын хөндий, уулсын хөндийд байршина.

Зүйлийг хянах аргууд

- Богино өвсний менежментийн аргыг хэрэглэх.
- Агаарын хөлгийн хөдөлгөөнт бүсэд хортон, шавьж устгах бодис ашиглах.

- Пиротехник (Bird Frite гэх мэт) болон ангийн буу хэрэглэх.

Популяцийн

- Популяцийн массыг бууруулахын тулд буудаж устгах.

Хар тодол

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн, үрждэг зүйл.

Таних шинж - бие гүйцсэн

- Биеийн өндөр- 20-22 см.

Эр бодгаль - Намар

- Бүрхүүл өд - Ногоон, ягаан өнгийн гялалзсан туяа бүхий хар.
- Нүд - хар.
- Хушуу- бараан.
- Хөл - Улаавтар хүрэн.

Эр бодгаль - Зун

- Бие бүхэлдээ - шар өнгийн жижиг толбо бүхий гялалзсан ногоо, сүүл богино.
- Хушуу- шар, хушууны уг хөхвөр саарал.

Эм бодгаль

Эр бодгальтай ижил боловч хушууны уг цайвар (хөх саарал биш)

Таних шинж - залуу шувуу

- Биеийн дээд хэсэг буюу нуруу - бүхэлдээ бор толбо бүхий сааралдуу бор.
- Биеийн доод хэсэг буюу хэвлий - бор.
- Хушуу- бараан бор.

Үржил ба үүрлэх орчин

- 5-р сарын сүүлчээс 6-р сарын эхэн үед үрждэг.

- Мод, хад, эрэг, барилга байгууламжид үүрлэнэ.
- Цайвар цэнхэр өнгийн 5-7 өндөг гаргадаг.

Бусад онцлог

- Чийгийн улаан хорхой, олон хөлтөн, бусад сээрнуруугүйтэн, түүний авгалдай, жимс, үрээр хооллоно.
- Задгай газраас илүүтэй өндөр өвстэй газрат байрлана.
- Сүргээрээ хооллож, нүүдэллэнэ.

Зүйлийг хянах аргууд

- Урт өвсний менежментийн аргыг ашиглах (20 буюу түүнээс урт)
- Агаарын хөлгийн хөдөлгөөнт бүсийн зүлэгжүүлсэн талбайд хортон шавьж, мэрэгчийн эсрэг хорт бодис ашиглах. ашиглах..
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх. Заримдаа ангийн буу ашиглах.
- Барилгын нүх хөндийг тороор битүүлэх.
- Харааны хөдөлгөөнт хэрэгслийг ашиглах (цаасан шувуу ашиглах, модон дээр металл гялтгануур, муурын метал дүрс өлгөх.
- Сүрэг шувуудыг идэш тэжээлээр хордуулах.

Алаг шаазгай

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй
Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үрждэг, суурин зүйл.

Таних шинж - бие гүйцсэн

- Бүрхүүл өд- Хар ба цагаан (тод ялгарна)
- Толгой - гялалзсан хар
- Сүүл: Урт, хар өнгө зонхилсон.
- Далавч -ногоон, эсвэл хөх өнгийн туяатай хар бөгөөд дэвэгч өдний дотор талын өрөвлөг цагаан.
- Зовхи - хар.
- Нүд - бараан.
- Хушуу- хар.
- Хөл - хар.
- Биеийн өндөр- 44-46 см

Таних шинж - залуу шувуу

- Биеийн дээд хэсэг буюу нуруу - цонхигор, туяарсан өнгө багатай
- Биеийн доод хэсэг -бие гүйцсэн бодгалийнхтай ижил
- Сүүл - бие гүйцсэн бодгалийнхаас богино.

Үржил ба үүрлэх орчин

- 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхэн үед модон дээр үүр засна.
- Цайвар цэнхэр, эсвэл ногоовтор цэнхэр туяатай 5-8 өндөг гаргана.

Бусад онцлог

- Хөрсний төрөл бүрийн сээрнуруугүйтэн, цох, царцаа, голио, хоёр нутагтан, мөлхөгч, шувууны өндөг, ангаахай, жижиг мэрэгч амьтад болон сэг зэмээр хооллоно. Улирлын шилжилтийнхээ үед болон өвлийн улиралд төрөл бүрийн ургамлын үр, жимс жимсгэнэ, хүний хүнсний хаягдлаар хооллодог.
- Сонгосон газар нутагтаа бүлээр амьдардаг.

Зүйлийг хянах аргууд

- Өндөр өвсний менежментийн арга техникийг ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) болон ангийн буу хэрэглэх.
- Урхиар барьж өөр газарт шилжүүлэн тавих.
- Үүрийг зайлуулах, эсвэл модыг тайрах.

Улаанхушуут жунгаа

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үрждэг, суурин зүйл. Монгол оронд өргөн тархалттай.

Таних шинж - бие гүйцсэн

- Их бие - Солонгорсон хар.
- Нүд - бараан.
- Хушуу- улаан, урт бөгөөд доош махир.
- Хөл - улаан.
- Биеийн урт- 30-40 см.

Таних шинж - залуу шувуу

- Их бие - Бие гүйцэсэн бодгальтай ижил.
- Нүд - бараан.
- Хушуу- улбар шар бөгөөд бие гүйцсэн шувууныхаас богино.
- Хөл - хар.

Үржил ба үүрлэх орчин

- 3-р сарын эхээр хад цохио, байгууламжийн завсар, хөндийд үүр засна.
- Цайвар ногоовтор өнгийн 3-4 өндөг гаргана.

Бусад онцлог

- Шавьж, аалз, чийгийн улаан хорхой, зөөлөн биетэн зэрэг хөрсний төрөл бүрийн сээрнуруугүйтнээр хооллоно. Улирлын шилжилтийнхээ үед болон өвлийн улиралд ургамлын үр, жимс, хог хаягдлаар хооллоно.

Зүйлийг хянах аргууд

- Өндөр өвсний менежментийн арга техникийг ашиглах.
- Барилга байгууламжийн нүх хөндийг торлох.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх..

Турлиах хэрээ

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Нүүдлийн, үрждэг, зарим нь өвөлждөг зүйл.

Таних шинж - бие гүйцсэн

- Биеийн бүх өд гялалзсан хар.
- Хар хэрээтэй ижил боловч хушууны угийн хэсэг өдгүй, хушуу хурц, дух өндөр зэргээрээ ялгарна.
- Нүд - хар.
- Хушуу-хар, угийн хэсэг өд, үсэнцэргүй, нүцгэн.
- Хөл - хар.
- Биеийн өндөр- 44-46 см.

Таних шинж - залуу шувуу

- Хар хэрээтэй тун төстэй. Хушуу хурц, дээд хушууны уг хэсэгт өдгүй.

Үржил ба үүрлэх орчин

- Навчит болон шилмүүст модны оройн хэсэг түүр засна.
- Бүл үүсгэн өөр хоорондоо ойрхон үүрлэнэ.
- 5-р сарын дундаас сүүлч үед үржинэ.
- Ногоовтор толбо бүхий цайвар цэнхэр, эсвэл цэнхэрдүү ногоон өнгийн 3-5 өндөг гаргана.

Бусад онцлог

- Суурнуруугүйтэн, ургамлын үр, жимс, царцаа, голио, аалз, чийгийн улаан хорхой болон сэг зэмээр хооллодог.
- Залуу шувууд эцэг эхийн хамт байх ба намрын улиралд сүрэглэдэг..

Зүйлийг хянах аргууд

- Өндөр өвсний менежментийн арга техник ашиглах.
- Зүлэгжүүлсэн талбайд шавьж, мэрэгч устгах бодис ашиглах.
- Пиротехник (Bird Frite гэх мэт) болон ангийн буу хэрэглэх.
- Үржлийн улирлын үеэр өндөг ба үүрийг устгах.
- Будаж устгах.

Carrion crow

Олон улсын хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Бүс нутгийн хамгааллын үнэлгээ: Анхааралд өртөхөөргүй

Статус ба тохиолдоц:

Үрждэг, суурин зүйл. Монгол оронд өргөн тархсан бөгөөд өмнөд нутгуудад хойд нутгуудтай харьцуулахад нягтшил бага.

Таних шинж - бие гүйцсэн

- Их бие- гялалзсан хар өдтэй. Турлиах хэрээний залуу шувуутай тун төстэй (Турлиах хэрээний таних шинжийг хар) бөгөөд хон хэрээнээс биеэр арай жижиг, сүүл нь тэгш өнцөгт хэлбэртэй (шаантаг хэлбэртэй биш), хушуу монхор бус, хаврын үсэнцэр богино.
- Нүд - dark.
- Хушуу-black.
- Feet - black.
- Биеийн өндөр- 40-50 см.

Таних шинж - залуу шувуу

- Их бие- бие гүйцсэн бодгалийнхтай ижил.
- Нүд - бараан
- Хушуу- хар
- Хөл - хар

Үржил ба үүрлэх орчин

- 4-р сарын сүүлч үеэр навчит болон шилмүүст мод, хад цохион дээр ихэвчлэн өмнөх жил үүрлэсэн газартаа үүр засна.
- Ногоовтор толбо бүхий цайвар цэнхэрдүү ногоон өнгийн 4-6 өндөг гаргана.

Бусад онцлог

- Хөрсний сээрнуруугүйтэн, сэг зэм, хүнсний хаягдал, ургамлын эд эрхтнээр хооллоно. Өвөлжиж буй сүргүүд нь хотын төв, суурин газар орчмын хогийн цэгүүдэд хооллодог.

Зүйлийг хянах аргууд

- Өндөр өвсний менежментийн арга техникийг ашиглах.

- Пиротехник (Bird Frite гэх мэт) хэрэглэх.
- Үхсэн амьтдыг зайлуулах, далдлах.
- Хог хаягдлын цэгүүдийн зохион байгуулалт, идэш тэжээлийн эх үүсвэрийг багасгахад орон нутгийн удирдах байгууллагын дэмжлэгийг авах.